



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО ТОГТВОРГУЙ, ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГУЙ БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: ТӨРӨӨС АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР
БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

АУДИТЫН КОД: НАГ-2025/19-ШТА-НА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2025 он

Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх
аудитор **Б.Баттуяа**

Утас: 260949 Цахим хаяг: battuyab@audit.gov.mn

Арга зүй, өгөгдлийн шинжилгээ хариуцсан менежер **Д.Баттулга**

Утас: 329875, Цахим хаяг: battulgad@audit.gov.mn

Аудитын менежер **П.Ундармаа**

Утас: 261839, Цахим хаяг: undarmaap@audit.gov.mn

Ахлах аудитор **Ш.Наранбаатар**

Цахим хаяг: naranbaatarsh@audit.gov.mn

Аудитор **Н.Хандмаа**

Цахим хаяг: khandmaan@audit.gov.mn

Аудитор **Н.Түмэнцэцэг**

Цахим хаяг: tumentsetsegn@audit.gov.mn

Аудитор **М.Минжин**

Цахим хаяг: minjinm@audit.gov.mn

Аудитор **М.Отгонбаяр**

Цахим хаяг: otgonbayarm@audit.gov.mn



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/154

Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримталж буй бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт” сэдэвт нийцлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд тус тус хүргүүлэхийг Нийцлийн аудитын газар (Б.Баттуяа)-т даалгасугай.

3.Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагын мэдээллийг статистик мэдээний бүртгэлд бүртгэж, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газарт хүргүүлэхийг Нийцлийн аудитын газар (Б.Баттуяа)-т даалгасугай.

4.Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор тус тус Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд (Ч.Ундрам)-д зөвлөсүгэй.

5.Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлага, тогтоосон төлбөрийн акт, хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудлын хэрэгжилтийг хангуулахад хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч (Б.Мөнхдөл), Нийцлийн аудитын газар (Б.Баттуяа)-т тус тус даалгасугай.

6.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг хадгаламжийн нэгж үүсгэн, Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг Нийцлийн аудитын газар (Б.Баттуяа)-т үүрэг болгосугай.



СМАГНАЙСҮРЭН



АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгтийн жагсаалт	3
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	5
БҮЛЭГ 1. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО, ТОГТОЛЦОО ТӨЛӨВШӨӨГҮЙ БАЙНА.	7
Аялал жуулчлалын салбарын тогтолцоо тогтворгүй байгаа нь үйл ажиллагааны хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.	7
Аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилтын хүрээнд тусгагдсан төсөл, арга хэмжээнүүд нь “Алсын хараа-2050” Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийн урт, дунд хугацааны зорилго, зорилтуудыг хангахад чиглэсэн байна.....	8
Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан төсөл, арга хэмжээ үр дүнгүй байна.	9
Үндэсний хорооны ажлын албаны үйл ажиллагаа зогссон, аялал жуулчлалын асуудлаар хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг нэгтгэн зохион байгуулах, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх ажил хангалтгүй байна.	11
“Монгол Улсын аялал жуулчлалын үндэсний нэгдсэн стратеги”-ийг боловсруулах гэрээг дүгнэх, зарим заалтыг хууль, журамтай нийцүүлэх шаардлагатай байна.....	12
БҮЛЭГ 2. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНГҮЙ БАЙНА.	13
Аялал жуулчлалын хөтөлбөрт зарцуулах санхүүжилтийг бодитой төлөвлөөгүй, хэрэгжилт хангалтгүй байна.....	13
Аялал жуулчлалын салбарыг дэмжих зээлийн хүүгийн хөнгөлөлтийг гэрээний ерөнхий шаардлагыг хангахгүй иргэн, аж ахуй нэгжид олгосон байна.....	15
Аялал жуулчлалын салбарт хэрэгжсэн хөтөлбөр, арга хэмжээ үр дүнгүй байна.	16
Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж буй аялал жуулчлалын гол зам дагуух амрах өртөө, түр отоглох цэгийн бүтээн байгуулалтын ажлын хэрэгжилт хангалтгүй байна.	18
Эрх шилжүүлэн авсан аялал жуулчлалын мэргэжлийн холбооны зарим гэрээний хэрэгжилт хангалтгүй байна.....	20
Монгол орныг түүх, соёл, газар нутгийн онцлогт тохируулан бүсчлэн хөгжүүлэх талаар бодлогын баримт бичиг, үзэл баримтлалд тусгагдсан ч аялал жуулчлалын бүсийг эцэслэн тогтоогоогүй байна.....	22
Аялал жуулчлалын тухай хуульд заасан журмыг батлах, салбарт мөрдөгдөж буй зарим үндэсний стандартыг шинэчлэх, шинээр батлах шаардлагатай байна.	22
Аялал жуулчлалын мэдээллийн нэгдсэн сангүйгээс олон нийтийг бодитой мэдээллээр хангаж чадахгүй байна.....	24
Жуулчдын тоон мэдээллийн талаарх статистик үзүүлэлтийг аргачлалын дагуу боловсруулаагүй, аялал жуулчлалын салбараас эдийн засагт оруулж буй хувь нэмрийг бодитой тооцох боломжгүй байна.....	26
Монгол Улсын албан ёсны статистик үзүүлэлт аялал жуулчлалын орлогыг бодитой тооцоолохгүй байна.....	27

ДҮГНЭЛТ	28
ЗӨВЛӨМЖ.....	30
ХАВСРАЛТ 1. Гадаадын хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний үйл явц.....	31

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж, ахуй нэгж
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЖМХ	Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо
АЖмХ	Аялал жуулчлалын тухай хууль
АЖХҮХ	Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хороо
АНУ	Америкийн Нэгдсэн улс
АНЭУ	Арабын Нэгдсэн Эмирт улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард улс
БОАЖ	Байгаль орчин, аялал жуулчлал
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗГ	Засгийн газар
МУХТЖҮЧ	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
НАГ	Нийцлийн аудитын газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НҮБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
ОХУ	Оросын Холбооны улс
ССАЖЗЯ	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
СТЗТҮИ	Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэл
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТӨААТҮГ	Төрийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТХГНТ	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай
УИХ	Улсын Их хурал
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман улс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХШУДАГ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Азийн бүс нутгийн зарим улсаас түүврээр жуулчдын тоо, орлого	6
Хүснэгт 2	Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичигт аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр туссан зорилго, зорилт, арга хэмжээ	8
Хүснэгт 3	МУ-ын хөгжлийн бодлогын баримт бичигт туссан төсөл, арга хэмжээ хоорондын уялдаа	8
Хүснэгт 4	Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан ТАХ-ний хэрэгжилтийн үнэлгээ /хувь/	10
Хүснэгт 5	“Аялал жуулчлалыг хөгжүүлнэ” тэргүүлэх чиглэлийн хэрэгжилт	10
Хүснэгт 6	Аялал жуулчлалын үндэсний хорооны 2024 онд гарсан тогтоолын хүрээнд гарсан Засгийн газрын тогтоол	11
Хүснэгт 7	Сайдын багцад тусгагдсан төсөв, гүйцэтгэлийн нэгтгэл	14
Хүснэгт 8	2025 оны ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтийн дүн	15
Хүснэгт 9	Зээлийн хүүгийн татаас олгосон иргэн, ААН-ийн тоо, олгосон санхүүжилт	15
Хүснэгт 10	Хэрэгжүүлсэн арга хэмжээ, зарцуулсан төсөв	16
Хүснэгт 11	Арга хэмжээний зардал баталсан тушаалын огноо, гэрээ байгуулсан, ажил гүйцэтгэсэн хугацаа	17
Хүснэгт 12	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй ТАХ-ний хэрэгжилт	19

Дүрслэлийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Монгол Улс дахь аялал жуулчлалын салбарын шилжилт, хөдөлгөөн	7
Дүрслэл 2	Монгол Улс дахь аялал жуулчлалын салбарын чиг үүрэг бүхий байгууллагуудын 2025 оны бүтэц зохион байгуулалт	7
Дүрслэл 3	Аялал жуулчлалын хөтөлбөрийн зардал баталсан тушаалын өөрчлөлт (сая.төгрөгөөр)	13
Дүрслэл 4	Аялал жуулчлалын хөтөлбөрийн зарцуулалт 2024 он /сая.төгрөгөөр/	14
Дүрслэл 5	Аялал жуулчлалын салбарын цахим платформын зураглал	25

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх, зорилго зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны "Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" А/108 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримталж буй бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт" сэдэвт нийцлийн аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилго

Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримталж буй бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд нийцлийн аудитыг гүйцэтгэж, Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтийн эрх ашигт нийцүүлэхэд чиглэн, дараах асуудлаар дүгнэлт зөвлөмж боловсруулав. Үүнд:

- Төрөөс аялал, жуулчлалыг хөгжүүлэх талаар баримталж буй бодлого хөгжлийн бодлогын баримт бичиг болон холбогдох хууль, тогтоомжтой нийцэж байгаа эсэх;
- Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаарх хөтөлбөр, арга хэмжээг үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн яам, Зам, тээврийн яам, Гадаад харилцааны яам /виз/, Аялал жуулчлалын үндэсний хороо, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо болон хуульд заасан холбогдох бусад байгууллагуудыг хамруулж мэдээ, судалгаа, шинжилгээ, гаргасан шийдвэрүүд болон бусад баримт материалын хүрээнд аудитыг гүйцэтгэв.

Аудитын арга зүй

Аудитын стандарт АДБОУС 100, нийцлийн аудитын стандарт АДБОУС 400, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, "Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам", "Нийцлийн аудитын заавар, аргачлал"-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх арга зүйг ашиглан гүйцэтгэж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын ашигласан шалгуур үзүүлэлт

- Аялал жуулчлалын тухай хууль, Алсын хараа 2050, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр,
- Засгийн газрын 2019 оны 333 дугаар тогтоолоор баталсан Төрөөс аялал, жуулчлалыг хөгжүүлэх талаар баримталж буй бодлого,
- Засгийн газрын 2015 оны 324 дүгээр тогтоолоор баталсан Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр.

Аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяа хянан удирдаж, арга, зүй өгөгдлийн шинжилгээ хариуцсан менежер Д.Баттулга арга зүйгээр хангаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер П.Ундармаа хэрэгжүүлж, ахлах аудитор Ш.Наранбаатар, аудитор Н.Хандмаа, Н.Түмэнцэцэг, М.Минжин, М.Отгонбаяр нар гүйцэтгэв.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улс аялал жуулчлалын тухай хуулийг анх 2000 онд 6 бүлэг, 24 зүйлтэйгээр баталсан бөгөөд холбогдох бусад хууль тогтоомжид орсон өөрчлөлт болон шинээр батлагдсан хууль, журамтай нийцүүлэхээр хуульд нийт 12 удаа нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Аялал жуулчлалын салбарын тогтвортой хөгжлийг хангах, эрх зүйн үндсийг бүрдүүлэх, салбарын тулгамдсан асуудлуудыг зохицуулах чиглэлээр, бусад салбарын уялдаа холбоо, зохицуулалт хангалтгүй байсантай холбогдуулан Аялал жуулчлалын тухай хуулийг шинэчлэн батлах хэрэгцээ шаардлага бий болсон байна.

Аялал жуулчлалын тухай хуулийг анх батлагдсанаас 23 жилийн дараа буюу 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр шинэчлэн баталж, дараах өөрчлөлтүүдийг оруулсан байна. Үүнд:

- Зарим орны иргэдийг Монгол улсад визгүй зорчуулах;
- Жуулчдын худалдан авалтад НӨАТ-ын буцаан олголт өгдөг байх;
- Тур оператор, тур агентуудыг эхний таван жилд орлогын албан татвараас хөнгөлөх;
- Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх;
- Аялал жуулчлалын дэд бүтэц бий болгох зэрэг онцлог зохицуулалтууд тусгагджээ.

Засгийн газрын 1999 оны 214 дүгээр тогтоолоор аялал жуулчлалын бодлогыг хэрэгжүүлэгч агентлаг “Аялал жуулчлалын газар”-ыг байгуулж, улмаар 2004 онд татан буугдаж, Зам тээвэр, аялал жуулчлалын яамны бүтцэд нэгтгэсэн байна.

Засгийн газрын 2008 оны “Яамдын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, зохион байгуулалтын бүтэц батлах тухай” 65 дугаар тогтоолоор Байгаль орчин, аялал жуулчлалын яамны бүтцэд аялал жуулчлалын нэгжийг шилжүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн “Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” 06 дугаар тогтоолоор Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас аялал жуулчлалын нэгж Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд шилжиж, 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн шинэчлэн батлах тухай” 07 дугаар тогтоолоор “Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газар” тухайн салбарын бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улсад 2025 оны байдлаар аялал жуулчлалын салбарт нийтдээ тур оператор 352, аяллын агент 20, зочид буудал 115, жуулчин тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэгч 20, хөтөч тайлбарлагч 105, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын нэгж 23 болон бусад чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 10 байгууллага аялал жуулчлалын салбарын үйлчилгээг үзүүлж байна.

Дэлхийн Аялал Жуулчлалын Байгууллага (UNWTO) нь тогтвортой, хүртээмжтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын бодлого, судалгаа, статистик, сурталчилгаа хийх, хөгжиж буй орнуудын аялал жуулчлалыг дэмжих, соёлын харилцан ойлголтыг нэмэгдүүлэх зорилго, чиг үүрэг бүхий НҮБ-ын төрөлжсөн байгууллага бөгөөд Монгол Улс 1990 онд гишүүн байгууллагаар элссэн байна.

Дэлхийн Аялал Жуулчлалын Байгууллагаас улирал тутамд нийтэлдэг “World Tourism Barometer” буюу “Дэлхийн аялал жуулчлалын чиг хандлагын тайлан”-д дараах судалгааг хийсэн байна. Хүснэгтээр харуулбал,

Хүснэгт 1. Азийн бүс нутгийн зарим улсаас түүврээр, жуулчдын тоо

Азийн зарим улс орон	Олон улсын жуулчдын ирэлт International Tourist arrival /сая/		Жуулчдын өсөлт /хувиар/
	2023	2024	
Япон	25.1	36.9	47
Тайланд	28.2	35.5	25.9
Вьетнам	12.6	17.5	38.9
Өмнөд Солонгос	11.0	16.4	49.1
Сингапур	10.3	12.4	20.4
Монгол Улс	0.59	0.73	23.7

Эх сурвалж: Дэлхийн Аялал Жуулчлалын Байгууллага (UN Tourism)

Дээрх хүснэгтээс харахад Монгол Улсад ирсэн жуулчдын тоо 0.14 сая жуулчин буюу 23.7 хувиар өссөн өндөр үзүүлэлттэй харагдах боловч абсолют өсөлт буюу бодит нэмэгдлээрээ бусад оронтой харьцуулахад харьцангуй бага байна.

Азийн аялал жуулчлалаар тэргүүлэх, өндөр ашиг орлоготой орнууд тогтолцоо нь тогтвортой, хэрэгжүүлэгч байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа нягт байгаагаас салбарын хөгжилд эерэг нөлөө үзүүлж байна. Тухайлбал:

- БНСУ нь (The Ministry of Culture, Sports and Tourism) буюу манай улстай ойролцоо тогтолцоогоор аялал жуулчлалын салбараа хөгжүүлж байна. БНСУ-ыг дотоод болон олон улсад сурталчлах тал дээр өөрсдийн соёлыг түлхүү түшиглэн хөгжүүлдэг, аялал жуулчлалын байгууллагатай (Korea Tourism Organisation) нягт хамтран ажилладаг. /ДНБ-ний 2 хувийг эзэлж байна/
- Сингапур улс, Аялал жуулчлалын зөвлөл (Singapore Tourism Board) нь шууд Засгийн газрын бодлогоор чиглүүлэгддэг, тогтолцооны хувьд хамгийн тогтвортой, залгамж чанар сайтай гэж үнэлэгддэг байна. /ДНБ-ний 5 хувийг эзэлж байна/
- Тайланд улс нь (Ministry of Tourism and Sports) буюу үйл ажиллагаа нь 2003 оноос хойш тогтвортой байна. /ДНБ-ний 9-10 хувийг эзэлдэг./

Дэлхийн Эдийн Засгийн Форумаас “Аялал жуулчлалын өрсөлдөх чадвар”-ын судалгааг зохион байгуулдаг бөгөөд “Аялал жуулчлалын зохицуулалт ба эрх зүй”, “Аялал жуулчлалын бизнесийн орчин ба дэд бүтэц”, “Хүн, байгаль ба соёлын нөөц” гэсэн бүлгүүдэд хуваагдах 14 чиглэлийн нийт 71 үзүүлэлт дээр тулгуурлан дэлхийн улс орнуудыг эрэмбэлэн жагсаадаг. Тухайлбал, салбарын бодлого чиглэл, журмын хэрэгжилт, байгаль орчны тогтвортой байдал, баталгаат ба аюулгүй байдал, эрүүл ахуй, аюулгүй орчин, ажиллагсдын эрүүл мэндийн байдал, аялал жуулчлалын салбарт оруулах хувь нэмэр, тээвэр ба дэд бүтэц, чадамж, мэдээлэл технологийн чадамж, хэрэглээ, хүний нөөцийн чадамж, ажлын баталгаат байр, салбарыг дэмжигч бусад салбарын нөлөөлөл, байгалийн нөөц, үнэ цэнэ, нөлөөлөл, соёлын нөөц гэх мэт үзүүлэлтүүд ордог байна.

Дээрх судалгааны Аялал жуулчлалын хөгжлийн индекс /Travel & Tourism Development Index/-ээр Монгол Улс 2021 онд 84 дүгээр байранд эрэмбэлэгдэж байсан бол 2024 онд 85 болж ухарсан нь хийж хэрэгжүүлж буй ажлын үр дүн, салбарын хөгжлийн түвшин хангалтгүй байгааг харуулж байна.

БҮЛЭГ 1. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО, ТОГТОЛЦОО ТӨЛӨВШӨӨГҮЙ БАЙНА.

Аялал жуулчлалын салбарын тогтолцоо тогтворгүй байгаа нь үйл ажиллагааны хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

- 1.1. Засгийн газрын тогтоолоор “Монгол Улсад аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар 1995-2005 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг баталж, Худалдаа Үйлдвэрийн Яаманд аялал жуулчлалын асуудал хариуцсан төрийн захиргааны нэгжийг бий болгож, аялал жуулчлалын салбар нь сүүлийн 30 жилийн хугацаанд дараах байдлаар 5 удаа шинэчлэгдсэн байна.

Дүрслэл 1. Монгол Улс дахь аялал жуулчлалын салбарын шилжилт, хөдөлгөөн



- 1.2. Монгол улсад аялал жуулчлалын асуудал хариуцсан захиргааны нэгжийн бие даасан статус байхгүй, бусад яамны бүтцийн нэгж хэлбэрээр явж ирсэн нь салбарын тогтолцоо төлөвшөөгүй, бие даасан байдал бүрдээгүйг харуулж байна.

Дүрслэл 2. Монгол Улс дахь аялал жуулчлалын салбарын чиг үүрэг бүхий байгууллагуудын 2025 оны бүтэц зохион байгуулалт



- 1.3. Аялал жуулчлалын салбарын байгууллагууд нь Аялал жуулчлалын тухай хуулиар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр байна.

- Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ, Засаг даргын бүрэн эрх /хуулийн 22-25 дугаар зүйл/
- Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны чиг үүрэг /хуулийн 6, 10, 12, 26 дугаар зүйл/
- Бусад оролцогчдын салбарын хууль тогтоомж болон АЖТХ-д заасан чиг үүрэг

- 1.4. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн “Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” 06 дугаар тогтоолоор¹ “Соёл, спорт, аялал жуулчлалын яам” байгуулагдан Байгаль орчин, аялал жуулчлалын яамны аялал жуулчлалын бодлого хариуцсан нэгж тухайн яаманд шилжсэн.

¹ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 07 дугаар тогтоолоор хүчингүй болсон.

1.5. Аялал жуулчлалын тухай хуулийн 26 дугаар зүйлээр аялал жуулчлалын мэргэжлийн холбооны бүрэн эрхийг хуульчилж, Монгол Улсын Засгийн газар 2023 онд “Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай” 370 дугаар тогтоолыг батлан, аялал жуулчлалын салбарт төрийн бус байгууллагын оролцоог нэг байгууллагаар гүйцэтгүүлэх эрх зүйн орчин бүрдсэн байна.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилтын хүрээнд тусгагдсан төсөл, арга хэмжээнүүд нь “Алсын хараа-2050” Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийн урт, дунд хугацааны зорилго, зорилтуудыг хангахад чиглэсэн байна.

1.6. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр 6 зорилго 12 зорилтын 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсанаас МУ-ыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 7, Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 2024 онд 30, 2025 онд 26 арга хэмжээ нь дэд бүтцийн /зам, 4с нисэх буудал/ чиглэлийн арга хэмжээ байна.

Хүснэгт 2. Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичигт аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр туссан зорилго, зорилт, арга хэмжээ

Бодлогын баримт бичиг	Зорилго	Зорилтын тоо	АХ-ний тоо
Алсын хараа-2050 /2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа/	6	12	33
МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	5	5	7
Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө	3	3	5 (30)
Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө	1	3	4 (26)

Эх сурвалж: Эрх зүйн нэгдсэн систем

1.7. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр 8 зорилгын хүрээнд 22 зорилтыг тусган хэрэгжүүлж буй нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилго, зорилт, үр дүнд хүрэхэд чиглэсэн байна.

1.8. Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр хөгжлийн бодлогын дунд болон богино хугацааны баримт бичигт туссан зорилт, арга хэмжээ нь “Алсын хараа -2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын зорилт, арга хэмжээтэй уялдаж байгаа нь ХБТТУтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.3-т “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг нь дунд болон богино хугацааны бодлого, төлөвлөлтийн үндэс байна” гэж заасантай нийцэж байна. Тухайлбал,

Хүснэгт 3. МУ-ын хөгжлийн бодлогын баримт бичигт туссан төсөл, арга хэмжээ хоорондын уялдаа (МУ-ын жилийн хөгжлийн төлөвлөгөөнд аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр туссан дэд бүтцийн арга хэмжээг хассан тоогоор)

№	Алсын хараа-2050 /2021-2030 он/ Зорилго, зорилт	АХ-ний тоо	МУХТЖҮЧ (2021-2025 он)	Хөгжлийн жилийн төлөвлөгөө 2024	Хөгжлийн жилийн төлөвлөгөө 2025
	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	5	1	-	3
1	Үндэсний бахархал, эв нэгдэл -Зорилт 1.1.	1	1	-	3
2	Нүүдлийн соёл иргэншилт монгол - Зорилт 1.2.	3	-	-	-
3	Дэлхийн монгол- Зорилт 1.5.	1	-	-	-
	Амьдралын чанар ба дундаж давхарга	2	1	-	-

1	Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес-Зорилт 3.3.	2	1	-	-
Эдийн засаг		11	1	3	1
1	Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд-Зорилт 4.2	8	1	3	1
2	Бүс нутгийн хамтын ажиллагаа Зорилт 4.4.	2	-	-	-
3	Үндэсний баялгийн сан- Зорилт 4.6	1	-	-	-
Ногоон хөгжил		1	-	-	-
1	Эх байгаль ба анхдагч Экосистем- Зорилт 6.1.	1	-	-	-
Бүс, орон нутгийн хөгжил		10	3	2	-
1	Аялал жуулчлал- Зорилт 8.2.	9	3	2	-
2	Тогтвортой хөдөө аж ахуй- Зорилт 8.3	1	-	-	-
Улаанбаатар ба дагуул хот		5	1	-	-
1	Хотын сайн засаглал - Зорилт 9.4	1	-	-	-
2	Дагуул хот - Зорилт 9.5	4	1	-	-
Нийт		33	7	5	4

1.9. Монгол Улсын хөгжлийн 2024, 2025 оны төлөвлөгөөнд дараах төсөл, арга хэмжээнүүд туссан байна. Үүнд:

- 2024 он
- Аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор виз олголтыг хялбаршуулах, визгүй зорчих боломжийг бүрдүүлэх;
- Хил орчмын болон хил дамнасан аялал жуулчлалын бүс нутгуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, жуулчид авто машинтайгаа аялах боломжийг бүрдүүлэх;
- Тусгай бүсийг аялал жуулчлалын тусгай сонирхлын нөөц, байршлын давуу талд тулгуурлан байгуулах;
- Палеонтологийн нөөцөд тулгуурлан “Аялал-Судалгаа-Амралт”-ын цогцолбор байгуулах; /Дундговь, Цагаан суварга/;
- Улирлын чанартай “Буйр нуур” усан замын боомт байгуулах;
- 2025
- Аялал жуулчлалын гадаад сурталчилгаа, маркетингийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- Байгаль, түүх, соёлын аялал жуулчлалын эвент арга хэмжээг зохион байгуулах;
- Гандантэгчэнлин хийд орчмын орон зайг "Далх, Тасганы дэнжийн Үндэсний соёлын өвийн дурсгалт газар" агуулгаар хөгжүүлж, "Буддын шашны соёлын өвийн цогцолбор" болгох;
- Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийг хэрэгжүүлэх.

1.10. Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ нь Алсын хараа 2050, МУХТЖҮЧ, ЗГҮАХ-ийн зорилго, зорилтыг хангахад чиглэгдэж, бодлогын баримт бичгийн уялдааг хангаж байна.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан төсөл, арга хэмжээ үр дүнгүй байна.

1.11. Аялал жуулчлалыг хөгжүүлэхээр хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байдлыг харьцуулан харуулбал:

Хүснэгт 4. Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан ТАХ-ний хэрэгжилтийн үнэлгээ /хувь/

№	Тодорхойлсон зорилго	бодлого,	ТАХ-ний тоо	Хэрэгжүүлэгч байгууллагын дундаж үнэлгээ	ЭЗХЯ-ны үнэлгээ	ЗГХЭГ-ын үнэлгээ	Аудитаар үнэлсэн үнэлгээ
Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл							
1	Бүс, орон нутгийн хөгжил		29	74.5	69.0	61.7	51.1

Эх сурвалж: УАГ-ын 2025 оны тайлан

1.12. Дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан дараах зорилтуудын хэрэгжилт хангагдаагүй нь үнэлгээнд нөлөөлсөн байна. Үүнд:

- Эдийн засгийн тэргүүлэх бүс нутаг, салбаруудыг дэд бүтцээр холбоно.
- Үндэсний онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

1.13. Харин Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан “Аялал жуулчлалыг хөгжүүлнэ” тэргүүлэх чиглэлд хамаарах арга хэмжээний хэрэгжилтийн дундаж үнэлгээ дараах байдалтай байна.

Хүснэгт 5. “Аялал жуулчлалыг хөгжүүлнэ” тэргүүлэх чиглэлийн хэрэгжилт

№	Үзүүлэлт	Аялал жуулчлалыг хөгжүүлнэ тэргүүлэх чиглэлийн үр дүн					Үнэлгээн ий дундаж хувь	Хариуцагч байгууллага
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнтэй	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	нийт		
1	Төсөл, арга хэмжээ	4	3	7	21	35	28.0	ССАЖЗЯ-2, ЗТЯ-32, ГХЯ-1

Эх сурвалж: УАГ-ын 2025 оны тайлан

1.14. Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан, салбарын яам хариуцан хэрэгжүүлэх дараах арга хэмжээнүүд хэрэгжээгүй байна. Үүнд:

- 4.1.1.3. “Тусгай бүсийг аялал жуулчлалын тусгай сонирхлын нөөц, байршлын давуу талд тулгуурлан байгуулах” арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах худалдан авах ажиллагаа удааширсан нь “4 тусгай бүс байгуулах” зорилтот үр дүнд хүрээгүй. /ССАЖЗЯ, 30 хувь, эрчимжүүлэх шаардлагатай/
- 4.1.1.4. “Палеонтологийн нөөцөд тулгуурлан “Аялал-Судалгаа-Амралт”-ын цогцолбор байгуулах /Дундговь, Цагаан суварга/” арга хэмжээний ТЭЗҮ боловсруулах санхүүжилт шийдэгдээгүйгээс “барилгын ажлын гүйцэтгэлийг 30 хувьд хүргэх” зорилтот үр дүнд хүрээгүй.

1.15. Санхүүжилттэй холбоотой 12, ТЭЗҮ батлагдаагүй болон худалдан авах ажиллагаа удааширсан 6, зохион байгуулалттай холбоотой 3 ТАХ зорилтот үр дүнг хангаагүй, нийт 35 ТАХ-ний 21 нь үр дүнгүй, дундаж үнэлгээ 28 хувьтай үнэлэгдсэн байна.

1.16. Аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлэхээр батлагдсан бодлого, хөтөлбөрийг хүчингүй болгохоор Засгийн газрын хуралдааны тэмдэглэлд тусгасан ч тогтоолоор баталгаажуулаагүй байна.

1.17. Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод “Аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж, эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгох, Монголд ирэх жуулчдын тоог нэг саяд хүргэх зорилтын хүрээнд Засгийн газрын 2015 оны 324 дүгээр тогтоолоор “Аялал жуулчлалын үндэсний хөтөлбөр”-ийг баталсан.

1.18. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 333 дугаар тогтоолоор тус салбарын хөгжлийг эрчимжүүлэн, салбарын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, цаашид аялал жуулчлалыг бүс нутгуудад жигд хөгжүүлэх замаар орон нутагт тогтвортой хөгжлийг хангах зорилтын хүрээнд “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-ыг баталсан.

1.19. Засгийн газрын хуралдааны 2021 оны 55 дугаар тэмдэглэлээр Аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, хөтөлбөрийг хүчингүй болгохоор тусгасан боловч процессын дараагийн арга хэмжээ аваагүйгээс бодлого, хөтөлбөр хуулийн нэгдсэн /www.legalinfo.mn/ сайтад хүчин төгөлдөр хэвээр байна.

Үндэсний хорооны ажлын албаны үйл ажиллагаа зогссон, аялал жуулчлалын асуудлаар хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг нэгтгэн зохион байгуулах, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх ажил хангалтгүй байна.

1.20. Төрийн захиргааны төв байгууллага хоорондын хамтын ажиллагааны талаар МУЯЭЗБТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Яамд нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд бодлого боловсруулах, хэрэгжүүлэхдээ шаардлагатай асуудлаар хамтарч ажиллана. Хамтран ажиллах асуудлын хүрээ нь хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын үүрэг даалгавраар болон холбогдох яамдын удирдлагын түвшинд харилцан тохиролцсоноор тодорхойлогдоно” гэж заасан байна.

1.21. Аялал жуулчлалын тухай хуулийн 20 дугаар зүйлд аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх чиглэлээр салбар хоорондын уялдааг хангах бүрэн эрхийг “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хороо²” хэрэгжүүлэхээр хуульчилсан.

1.22. “Үндэсний хороог Ерөнхий сайд тэргүүлэх бөгөөд байгаль орчин, аялал жуулчлалын, төсөв, санхүүгийн, эдийн засгийн, тээврийн, эрчим хүчний, гадаад харилцааны, хууль зүйн болон соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосон тус бүр нэг, энэ хуулийн 26.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдээс санал болгосон таван гишүүнээс бүрдэнэ” гэж АЖТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан.

1.23. Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хорооны ажиллах журмын дагуу салбарын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх ээлжит хуралдааныг сар тутам хийхээр зохицуулагдсан.³ Үндэсний хороо үүсгэн байгуулагдсанаас хойш 2024 онд 4, 2025 онд 1, нийт 5 удаа хуралдаж, доорх асуудлыг шийдвэрлэхээр 5 тогтоол гаргасан бөгөөд уг тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд ЗГ-ын 4 тогтоол гарсан байна. Үүнд:

Хүснэгт 6. АЖХҮХ-ны 2024 онд гарсан тогтоолын хүрээнд гарсан Засгийн газрын тогтоол

Үндэсний хорооны тогтоол утга	Тогтоолын дугаар		Засгийн газрын тогтоолын агуулга
	АЖХҮХ	ЗГ	
Хил орчмын аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулах, жуулчдын аюулгүй байдлыг хангах журмыг боловсруулан батлуулах	24/01	142	Хил орчмын аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулах, жуулчдын аюулгүй байдлыг хангах журам баталсан байна.
Аялал жуулчлалын бүс нутгууд болон авто замын дагуу барьж байгуулах ариун цэврийн байгууламж, үйлчилгээний цогцолборын газрын асуудлыг шийдвэрлэх	24/02	189	Ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор барьж байгуулах тухай тогтоолд 21 аймгийн 58 байршлын газрын асуудлыг шийдвэрлэхээр тусгасан байна.
Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн нутгийг хамруулсан “Түүхэн аялал жуулчлалын бүсийг хөгжүүлэх төлөвлөгөө”-г Засгийн газрын хуралдаанд танилцуулж шийдвэрлэх	24/03	239	“Түүхэн аялал жуулчлалын бүсийг хөгжүүлэх төлөвлөгөө”-г батлах тухай
Монголд зочлох жилийн гадаад сурталчилгаа, Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх	24/04	191	Жуулчдын урсгалыг нэмэгдүүлж, дөрвөн улирлын турш жуулчин хүлээн авах зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Эх сурвалж: Аялал жуулчлалын үндэсний хорооны 2024 оны үйл ажиллагааны үр дүнгийн тайлан

1.24. Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хороо нь өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах ажлын албыг байгуулсан ч 2025 оны 10 дугаар сарын байдлаар ажлын албаны

² АЖТХ-ийн 20.1.3-т “аялал жуулчлалын асуудлаар салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангах”
³ “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хорооны ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3.Үндэсний хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдааныг танхимаар хийх бөгөөд шаардлагатай бол цахимаар хийж болно.

ажилтны хөдөлмөрийн гэрээний хугацаа дууссан, чөлөөлсөн тушаал, шийдвэр гараагүй, үндэсний хорооны ажлын албаны үйл ажиллагаа зогссон байдалтай байна.

- 1.25. Иймд АЖТХ-ийн дагуу “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хороо” үйл ажиллагаагаа эрчимжүүлэх, аялал жуулчлалын салбар хариуцсан төрийн захиргааны байгууллага нь аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр гарсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг үндсэн хэрэгжүүлэгчийнхээ хүрээнд нэгтгэн дүгнэх шаардлагатай байна.

“Монгол Улсын аялал жуулчлалын үндэсний нэгдсэн стратеги”-ийг боловсруулах гэрээг дүгнэх, зарим заалтыг хууль, журамтай нийцүүлэх шаардлагатай байна.

- 1.26. ССАЖЗ-ын сайдын 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/78 дугаар тушаалаар баталсан “ССАЖЗ-ын сайдын эрхлэх асуудлын хүрээний 2025-2028 оны стратеги төлөвлөгөө”-ний стратегийн зорилгын 5.1-т “Аялал жуулчлалын салбарын стратегийг боловсруулж хэрэгжүүлнэ” гэж тусгасан байна.
- 1.27. Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 24/04 дүгээр хуралдаанаар “Монгол Улсын аялал жуулчлалын үндэсний нэгдсэн стратеги”-ийг хэрхэн боловсруулах болон тус ажлыг гүйцэтгүүлэхээр олон улсын зөвлөх үйлчилгээний асуудлыг хэлэлцэж, тухайн өдрөө Засгийн газрын 125 дугаар “Монгол Улсыг олон улсад сурталчлах зарим арга хэмжээний тухай”⁴ тогтоолын хавсралтаар “Бостон Консалтинг групп”-тэй гэрээ байгуулахыг баталсан байна.
- 1.28. ССАЖЗЯ, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо болон Бостон Консалтинг группийн гуравласан гэрээний “Саналын захидал”⁵-аар 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр гэрээний гол нөхцөл болох гэрээний төлбөр, хугацаа болон гүйцэтгэх ажлыг тохиролцож, баталгаажуулан гэрээний үнийн 30 хувийг шилжүүлж стратегийг боловсруулах ажлыг эхлүүлсэн байна. Иймд “Аялал жуулчлалын үндэсний хөгжлийн стратеги” боловсруулах гуравласан гэрээг дүгнэх, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай төлөвлөх, зарцуулах зарчимд нийцүүлэн үлдэгдэл төлбөрийг шилжүүлэхгүй байхад анхаарах нь зүйтэй байна.
- 1.29. Засгийн газрын 2017 оны 57 дугаар тогтоолоор “Байгууллага хоорондын гэрээ байгуулах журам” батлагдсан⁶ ч зорилтыг нь хуульд нийцүүлээгүй баталсан байна. Тухайлбал, Захиргааны ерөнхий хуулийн 54.2-т “Захиргааны байгууллага гадаад улсын ижил төрлийн захиргааны байгууллага, хуулийн этгээдтэй байгуулах байгууллага хоорондын гэрээ ..” гэснийг журмын зорилтын агуулгаас хуулийн этгээд гэсэн субъектийг алдагдуулан баталсан байна.
- 1.30. Салбарын хөгжлийн стратеги, бодлогын үндсэн чиглэлийг тодорхойлох, олон улсад аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх бодлого боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах зэрэг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны үндсэн чиг үүргийг олон улсын зөвлөх үйлчилгээ авч, гадаадын хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний үе шатанд хийгдэх анхан шатны баримт бичгүүд, удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа, мэдээлэл лавлагааны баримт бичгийг тухай бүр баримтжуулах, хяналт тавьж ажиллах шаардлагатай байна. *Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс үзнэ үү.*

⁴Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3.Энэ хууль бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой дараах харилцааг зохицуулахад хамаарахгүй:

3.3.6.Засгийн газраас Монгол Улсыг гадаад улсад сурталчлахтай холбоотойгоор гадаад улсаас бараа худалдан авах, үйлчилгээ авах, гадаад улсаас соёлын биет өв болон түүний хуулбарыг өмчлөгчтэй тохиролцон худалдан авах ажиллагаа;

⁵ Иргэнийн хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.2-т “хэлцэл хийх тухай саналыг зөвшөөрсөн талын хүсэл зоригийг илэрхийлсэн захидал...”, 43.2.3.хуульд зааснаар бүртгүүлэх буюу ... зохих хэлцлийг ийнхүү бүртгүүлсэн буюу гэрчлүүлсэн”, 50.1-т “Хэлцэл хүчин төгөлдөр байх зайлшгүй нөхцөл болсон зөвшөөрөл олгох эрх, үүрэг бүхий гуравдагч этгээд уг зөвшөөрлийг олгосон буюу олгохоос татгалзсан тухайгаа хэлцлийн талуудад нэгэн адил мэдээлнэ”, 195 дугаар зүйлийн Гэрээ байгуулах санал, 195.1-т “Нэг этгээд өөрийн хүсэл зоригийг хүлээн зөвшөөрсөн этгээдтэй эрх үүргийн хувьд холбогдохоор нэг буюу хэд хэдэн тодорхой этгээдэд хандан хүсэл зоригоо бодитойгоор, хангалттай тодорхой илэрхийлсэн илэрхийллийг гэрээ байгуулах санал гэнэ.”


⁶ Захиргааны ерөнхий хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4.Энэ хуулийн 54.2, 54.3-т заасан гэрээг хянаж, бүртгэхтэй холбоотой журмыг Засгийн газар батална.

БҮЛЭГ 2. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНГҮЙ БАЙНА.

Аялал жуулчлалын хөтөлбөрт зарцуулах санхүүжилтийг бодитой төлөвлөөгүй, хэрэгжилт хангалтгүй байна.

2.1. Аялал жуулчлалын хөтөлбөрийн 2024 оны зардлын хуваарийг БОАЖ-ын Сайдын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/73 дугаар тушаалаар 12,799.8 сая төгрөг байхаар баталсан ч тус хуваарийг А/174, А/239, А/449 дүгээр тушаалуудаар өөрчилж, нийт дүнг 13,199.8 сая төгрөг болгон нэмэгдүүлсэн байна. Үүнд:

Дүрслэл 3. Аялал жуулчлалын хөтөлбөрийн зардал баталсан тушаалын өөрчлөлт (сая.төгрөгөөр)



2.2. БОАЖ-ын Сайдын А/174 дүгээр тушаалаар хөтөлбөрийн арга хэмжээний тоо, төсвийн дүнд өөрчлөлт ороогүй, гагцхүү холбогдох албан тушаалтанд чиг үүргийг олгосон бол А/239, А/449 дүгээр тушаалуудаар арга хэмжээний тоо, төсвийн дүнг өөрчлөн баталсан нь хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, холбогдох тооцоо, судалгаа хангалтгүй байгааг харуулж байна.

2.3. Аялал жуулчлалын хөтөлбөрийн 2024 оны арга хэмжээнээс төсөв хасагдсан 5, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулаагүй 1,672.0 сая төгрөгийн 21 арга хэмжээ байна.

Дүрслэл 4. Аялал жуулчлалын хөтөлбөрийн зарцуулалт 2024 он /сая.төгрөгөөр/



2.4. Аялал жуулчлалын хөтөлбөрийн батлагдсан хөрөнгөнөөс төлөвлөгөөнд тусгагдаагүй ч аялал жуулчлалыг хөгжүүлэхтэй холбоотой бусад арга хэмжээнд зарцуулсан байна. Тухайлбал,

- Цахим орчинд аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг байршуулан сурталчлахад шаардагдах зардал-343.8 сая төгрөг;
- Ерөнхий сайдын Арабын нэгдсэн Эмирт улс, Бахрейны Хаант улсад хийх айлчлал-35.3 сая төгрөг;
- МУ-ыг гадаадад сурталчлах зорилгоор ОХУ-ын Буриад улсад аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах арга хэмжээг зохион байгуулах-22.2 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2.5. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар батлагдсан салбарын сайдын урсгал зардлаас Аялал жуулчлалын хөтөлбөрт нийт 35,304.1 сая төгрөгийн санхүүжилт тусгасан байна. Үүнээс үндсэн үйл ажиллагааны зардалд 10,263.0 сая төгрөг, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэхэд 5,000.0 сая төгрөг, хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас 20,041.1 сая төгрөгөөр тооцсон байна.

2.6. Төсвийн тодотгол болон салбарын сайдын тушаалаар 2025 оны төсвийн хуваарьт орсон өөрчлөлт болон гүйцэтгэл 2025 оны 10 дугаар сарын 23-ны байдлаар дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 7. Сайдын багцад тусгагдсан төсөв, гүйцэтгэлийн нэгтгэл /2025 оны 01-10 сар/

Аялал жуулчлалын хөтөлбөрийн зардал	2025.01.13-ны А/04 тушаал	төсвийн тодотголоор буурсан дүн	2025.07.28-ны А/269 тушаалаар өөрчлөгдсөн	гүйцэтгэл 2025.10.23-ны байдлаар
Үндсэн үйл ажиллагааны зардал	10,263.0	5,519.7	6,244.4	1,967.8
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	20,041.1	8,723.4	1,221.9	736.9
Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	5,000.0	1,488.0	2,003.0	1,567.0
Нийт дүн	35,304.1	15,731.1	9,469.3	4,271.7

2.7. “Зардал баталж, эрх шилжүүлэх тухай” ССАЖЗ-ын сайдын 2025 оны А/73 дугаар тушаалын дагуу АЖМХ-оор төрийн зарим чиг үүргийг 4,000.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдөр ССАЖЗЯ/25/22 тоот гэрээг байгуулж, гэрээний хавсралтаар нийт 16 арга хэмжээний зардлын хуваарийг баталсан байна.

2.8. Үүнээс 4 арга хэмжээний хүрээнд нийт 2,190.0 сая төгрөгийн 13 гэрээ байгуулж, урьдчилгаа төлбөрт 1,547.0 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

Хүснэгт 8. 2025 онд гүйцэтгэх ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийн дүн /сая.төгрөгөөр/

№	Арга хэмжээ	Батлагдсан төсөв	Санхүүжилт олгосон дүн	Үлдэгдэл төлбөр	
1	Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох	ITB-Берлин	273.0	273.0	-
		СОТТМ-Бээжин	170.0	170.0	-
		SITF-Солонгос	100.0	70.0	30.0
		JATA-Япон	180.0	126.0	54.0
		CITM-Шанхай	187.0	-	187.0
		WTM-Лондон	190.0	133.0	57.0
		TOP RESA-Франц	70.0	49.0	21.0
		Лас вегас трэйвэл шоу-АНУ	150.0	-	150.0
	Lets travel-Москва	80.0	56.0	24.0	
2	Аялал жуулчлалын дотоодын эвентүүдийг дэмжин хамтран зохион байгуулах	"Tourism week-2025"	300.0	300.0	-
		Эвент арга хэмжээ	170.0	170.0	-
3	Мөсөн сийлбэрчдийн олон улсын уралдаан	220.0	220.0	-	
4	Жуулчны хөтөч-тайлбарлагчдад зориулсан нэгдсэн сан бүрдүүлэх, үнэмлэх олгох ажлыг зохион байгуулах	100.0	-	100.0	
Нийт дүн			1,547.0	623.0	

2.9. Харин гүйцэтгэгчтэй гэрээ байгуулаагүй 1,810.0 сая төгрөгийн 7 арга хэмжээ байна. Үлдсэн 5 арга хэмжээний хувьд төсөв батлагдаагүй, салбарын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах арга хэмжээнүүд байна.

Аялал жуулчлалын салбарыг дэмжих зээлийн хүүгийн хөнгөлөлтийг гэрээний ерөнхий шаардлагыг хангахгүй иргэн, аж ахуй нэгжид олгосон байна.

2.10. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний⁷ хэрэгжилтийн хүрээнд 2023 онд “Аялал жуулчлалын салбарыг дэмжих зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээг “Сангийн яам, БОАЖЯ, Монгол банк” нийт 10 арилжааны банкттай байгуулсан байна.

2.11. Уг гэрээнд арилжааны банкнаас нэг зээлдэгчид 1,000.0 сая төгрөгийн зээлийг 2 жилийн хугацаатай, жилийн 18 хувиас хэтрэхгүй хүүтэйгээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд олгож, Засгийн газраас жилийн 7 хувийн хүүгийн хөнгөлөлт үзүүлэхээр тусгасан байна.

2.12. “Аялал жуулчлалын салбарыг дэмжих” зээлийг 6 арилжааны банкнаас 4 иргэн, 47 аж ахуйн нэгжид олгож, зээлийн хүүгийн хөнгөлөлт /татаас/-д нийт 1,591.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Үүнд:

Хүснэгт 9. Зээлийн хүүгийн татаас олгосон иргэн, ААН-ийн тоо, олгосон санхүүжилт /сая.төгрөгөөр/

№	Арилжааны банкны нэр	Зээлдэгчийн тоо		Нийт зээлийн дүн	Хүүгийн хөнгөлөлт олгосон дүн		
		Иргэн	ААН		2024 он	2025 он	Нийт
1	Ариг банк	-	1	1,000.0	45.8	9.7	55.5
2	Капитрон банк	-	1	1,000.0	36.3	26.8	63.2
3	Хас банк	2	9	3,600.0	124.8	95.9	220.7
4	Голомт банк	2	13	7,701.3	211.5	229.6	441.1
5	Худалдаа хөгжлийн банк	-	9	5,300.0	167.8	184.2	352.0
6	Хаан банк	-	14	6,157.4	268.0	190.7	458.7
Нийт дүн		4	47	24,758.7	854.2	736.9	1,591.1

⁷ Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 431 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан

2.13. Үүнээс “Санхүүжилтийн ерөнхий гэрээ”-нд тусгасан зээлийн шаардлагыг хангаагүй 4,537.8 сая төгрөгийн зээлд нийт 257.8 сая төгрөгийн зээлийн хүүгийн хөнгөлөлт олгосон байна. Үүнд:

- Гэрээний “3.1.1.Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлсэн, эсвэл нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдсөн байх” шаардлагыг хангаагүй 4 иргэн, 7 ААН-д нийт 151.4 сая төгрөгийн зээлийн хүүгийн хөнгөлөлт,
- Мөн “3.1.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт 12 сараас доошгүй хугацаанд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлсэн байх” шаардлагыг хангаагүй 3 ААН-д 106.4 сая төгрөгийн зээлийн хөнгөлөлтийг тус тус олгосон байна.

2.14. Мөн гэрээний “7.1.Монгол банк, Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран “Аялал жуулчлалын салбарыг дэмжих зээл”-ийн хэрэгжилт, банкнуудын аж ахуйн нэгжид олгосон зээлийн явцын хяналт, шалгалтыг Монгол банкнаас баталсан холбогдох журам, зааврын дагуу жилд нэгээс доошгүй удаа хийж, хяналт тавина” гэж заасан боловч өнөөдрийг хүртэл явцын хяналт, шалгалт хийгээгүй байна.

2.15. Иймд “Санхүүжилтийн ерөнхий гэрээ”-ний 3.1.1, 3.1.2-т заасан шаардлагыг хангаагүй байхад зээлийн хүүгийн татаас олгосон 257.8 сая төгрөгийг Улсын төсөвт буцаан төвлөрүүлэх “Албан шаардлага” хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Аялал жуулчлалын салбарт хэрэгжсэн хөтөлбөр, арга хэмжээ үр дүнгүй байна.

2.16. Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр 2024-2025 онд дотоод, гадаад сурталчилгаа, олон улсын үзэсгэлэн зэрэг 101 арга хэмжээнд нийт 13,276.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 10. Хэрэгжүүлсэн арга хэмжээ, зарцуулсан төсөв (сая.төгрөгөөр)

№	Арга хэмжээ	Арга хэмжээний тоо	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Монгол орныг гадаадад сурталчлах "Go mongolia" арга хэмжээг зорилтот орнуудад зохион байгуулах(Орос, Хятад, Солонгос, Япон, Герман, Америк, Франц, Турк, Сингапур, Швейцар г.м)	12	2,441.2	2,345.6
2	Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, арга хэмжээнд оролцох(ITB, MiTT, KOTFA, WTM, JATA, PAMA, IFTM, CITM, COTTM, Швейцарын үзэсгэлэн г.м)	19	2,716.9	1,976.2
3	Нөлөөлөгчдийг урьж, Монгол улсыг сурталчлах	5	1,512.0	811.8
4	Мазаалай олон улсын мөсөн урлалын наадам	2	1,764.7	1,879.2
5	Дотоодын арга хэмжээ	27	1,261.0	1,182.2
6	Улсын болон Олон улсын байгууллагатай хамтарч ажиллах	19	2,542.3	2,188.0
7	Аялал жуулчлалыг хөгжүүлэх 55 тэрбумын хөнгөлөлттэй зээлийн хүүгийн татаас	-	3,778.0	1,591.1
8	Аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлсэн бусад арга хэмжээ	17	1,647.5	1,301.9
	Нийт	101	17,663.6	13,276.0

2.17. Дээрх арга хэмжээг зохион байгуулахтай холбоотойгоор дараах зөрчил илэрч байна.

- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Аялал жуулчлалын мэргэжлийн холбоогоор 2024 онд гүйцэтгүүлэх 20 арга хэмжээний хүрээнд 31 тушаал гаргаж, ажил гүйцэтгэх гэрээ байгуулж ажилласан. Үүнээс 2,774.6 сая төгрөгийн 18 тушаал, гэрээг ажил гүйцэтгэсний дараа нөхөж байгуулсан байна. Тухайлбал:

Хүснэгт 11. Арга хэмжээний зардал баталсан тушаалын огноо, гэрээ байгуулсан, ажил гүйцэтгэсэн хугацаа

№	Арга хэмжээ	Төсөв /сая.төг/	Тушаалын огноо, дугаар		Гэрээ байгуулсан огноо, дугаар		Ажил гүйцэтгэсэн хугацаа
1	БНХАУ-ын Бээжин, ХонгКонг, Гуан Жао хотод зохион байгуулсан "Go mongolia" рөүдшоу	149.2	2024.05.30	A/229	2024.06.06	24/243	2024.03.01
2	Мазаалай олон улсын мөсөн урлалын наадам	765.1	2024.03.21	A/108	2024.03.21	24/102	2024.01.14
3	Өвлөлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөөний өвлийн улиралд ажиллах жуулчны баазуудын цахилгааны хөнгөлөлт	365.4	2024.06.19	A/284	2024.06.20	24/291	2024.01.01

- 2.18. Дээрх хүснэгтээс харахад арга хэмжээг хийж гүйцэтгэсний дараа 2-5 сарын дараа ТНБД-ын тушаал гарч, гэрээг нөхөн байгуулсан байна.
- 2.19. Иргэний хуулийн 343 дугаар зүйлд заасан Ажил гүйцэтгэх гэрээ нь ирээдүйд чиглэсэн элементийг агуулсан байдаг, гэрээний зүйл нь зарчмын хувьд ирээдүйд гүйцэтгэх үүрэг байна. Гэтэл талууд зохион байгуулагдаад дууссан буюу бэлэн болсон ажлыг гүйцэтгүүлэхээр “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулж байгаа нь ажил гүйцэтгэх гэрээний агуулгад нийцэхгүй байна.
- 2.20. Иймд хөрөнгө гаргахтай холбоотой тушаал, шийдвэрийг нөхөж үйлдэхгүй, ажил гүйцэтгэх гэрээг холбогдох хуульд заасны дагуу байгуулах нь зүйтэй байна.
- 2.21. Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Аялал жуулчлалын мэргэжлийн холбоотой байгуулсан гэрээний биелэлтийг бодитоор дүгнэж, хяналтыг бүрэн хэрэгжүүлэхгүй байна. Тухайлбал,
- “Жуулчдаа дайлах монгол зоог” арга хэмжээний “Ажил гүйцэтгэх гэрээ”-ний ажлын даалгаварт аль болох олон улсын байгууллагуудын оролцоог хангаж ажиллах гэж тусгасан ч зохион байгуулалтад олон улсын байгууллагуудыг оролцуулаагүй;
 - “Далины баяр-2024” арга хэмжээний “Ажил гүйцэтгэх гэрээ”-ний ажлын даалгаварт дотоод гадаадын жуулчны тоог гарган орон нутгийн иргэдэд хэдэн төгрөгийн орлого оруулсан талаар судалгаа гаргахаар тусгасан ч судалгааг гаргаагүй, хавсаргаж ирүүлээгүй;
 - 2025 онд зохион байгуулсан СОТТМ, SITF олон улсын үзэсгэлэн, Мөсөн сийлбэрчдийн олон улсын уралдаан зэрэг арга хэмжээнүүдийн “Ажил гүйцэтгэх гэрээ”-ний ажлын даалгаварт “Үзэсгэлэнгийн үзэгч, сонирхогчдоос сэтгэл ханамжийн судалгаа авч дүгнэхээр тусгасан боловч зохион байгуулалтад оролцогчдоос сэтгэл ханамж, үр дүнгийн судалгаа хийгдээгүй байна.
- 2.22. Арга хэмжээний хэрэгжилтийн үе шат бүрд тавих захиалагчийн хяналтыг сайжруулж, гүйцэтгэлийг бодитоор дүгнэх шаардлагатай байна.
- 2.23. Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо Төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэхдээ худалдан авах ажиллагааг өөрсдийн баталсан “Худалдан авах ажиллагааны журам”⁸-ын дагуу явуулж байна.
- 2.24. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.1⁹, 9.1¹⁰ дэх хэсэг, 2023 оны “Төрийн зарим чиг үүргийг Засгийн газрын бус

⁸ АЖМХ-ны Удирдах зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/01/24 дугаар тогтоол, 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн №31/25 дугаар тогтоол

⁹ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д “Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө

¹⁰ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1. Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ.

байгууллагаар гүйцэтгүүлэх тухай Ерөнхий гэрээ”-ний 4.1¹¹, 2024 оны “Төрийн зарим чиг үүргийг Засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай гэрээ”-ний 6.10¹² дахь заалтуудыг тус тус зөрчиж байна.

- 2.25. Яамнаас Аялал жуулчлалын мэргэжлийн холбоонд хууль тогтоомжийг мөрдөж ажиллах талаар мэргэжил, арга зүйн зөвлөмж өгөөгүй, хяналтын чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй нь гэрээний 3.2¹³-т заасныг зөрчсөн байна.
- 2.26. Иймд Төсвийн хөрөнгөөр худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа холбогдох хуулийг дагаж мөрдөх, Төрийн худалдан авах ажиллагаа зохион байгуулдаг /tender.gov.mn/ сайтад бүртгүүлэх, худалдан авах ажиллагаатай холбоотой зар, мэдээг байршуулах талаар холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах нь зүйтэй байна.
- 2.27. Аялал жуулчлалын хөтөлбөрт 2024-2025 онд төлөвлөгдсөн нийт арга хэмжээний 55 арга хэмжээнд 5,740.0 сая төгрөгийг бүхэл дүнгээр төлөвлөж, өртөг зардлын тооцооллыг бодитой хийгээгүй байна. Тухайлбал,

- Мөсний загасчлалын дэлхийн аварга шалгаруулах тэмцээн – 100.0 сая төгрөг;
- Дэлхийн аялал жуулчлалын өдөр, Монголын аялал жуулчлалын салбар үүсгэн байгуулагдсаны 70 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх – 100.0 сая төгрөг;
- Дотоодын аялал жуулчлал, өвлийн аялал жуулчлалыг дэмжих төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх (“Нэг жуулчин-Нэг хонь” хөтөлбөр) -300.0 сая төгрөг;
- “Tourism week” хөрөнгө оруулалтын олон улсын хурал зохион байгуулах- 800.0 сая төгрөг;
- Монгол улсыг гадаад дотоодод сурталчлах нөлөөлөгчдийг урьж, сурталчлуулах/Nas Summit Mongolia/ - 700.0 сая төгрөг;
- Монгол Улсыг сурталчлах “Go Mongolia” арга хэмжээг голлох зах зээлийн орнуудад зохион байгуулах/БНХАУ, ОХУ, БНСУ, Япон, ХБНГУ, АНУ, Тайван, АНУ, Вьетнам г.м 10 гаруй улсад/ - 1,000.0 сая төгрөг;
- “Адал явдалт аялал жуулчлалын холбооны бүсийн уулзалт, форум”-ыг Монгол Улсад зохион байгуулах – 200.0 сая төгрөг;
- Жуулчны хөтөч-тайлбарлагчдад зориулсан нэгдсэн сан бүрдүүлэх, үнэмлэх олгох ажлыг зохион байгуулах – 100.0 сая төгрөг.

- 2.28. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.7¹⁴-д заасантай нийцэхгүй байна. Аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн тооцооллыг Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2¹⁵-т нийцүүлэн үнийн судалгаанд үндэслэн бодитой тооцож байх нь зүйтэй.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж буй аялал жуулчлалын гол зам дагуух амрах өртөө, түр отоглох цэгийн бүтээн байгуулалтын ажлын хэрэгжилт хангалтгүй байна.

- 2.29. Улсын хөгжлийн 2024, 2025 оны төлөвлөгөөнд аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилтын хүрээнд авто зам барих ажлууд Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тусгагдсан байна.
- 2.30. Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний “Аялал жуулчлалыг хөгжүүлнэ” тэргүүлэх чиглэлд Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх авто замын 24 ТАХ тусгагдсанаас 17 ТАХ-ний хэрэгжилт дунджаар 59 хувьтай, 7 ТАХ-г хэрэгжүүлэх санхүүжилт шийдвэрлэгдээгүй байна.

¹¹ Гүйцэтгэгч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн Хууль, Аялал жуулчлалын тухай хууль, Захиргааны Ерөнхий хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдлөг болгон гэрээнд заасан чиг үүргийг гүйцэтгэх үүргийг хүлээнэ.

¹² Холбоо нь энэхүү гэрээний хавсралтад заасан арга хэмжээний зардлаас өөр бусад арга хэмжээг зохион байгуулах, батлагдсан зардлын хэмжээг нэмэгдүүлэх, өр үүсгэх, гуравдагч этгээдтэй худалдан авах ажиллагааны болон бусад хууль тогтоомжийг зөрчиж гэрээ байгуулахыг хориглоно.

¹³ Гэрээний 3.1-д заасан чиг үүргийг гүйцэтгүүлэхтэй холбогдолтой хууль тогтоомж, ... болон мэргэжил, арга зүйн зөвлөмж, удирдлагаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг хүлээнэ

¹⁴ Аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх;

¹⁵ Төсвийн тухай хуулийн 14.2.2.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох;

- 2.31. Харин Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний “Дөрвөн улирлын аялал жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээг хөгжүүлнэ” зорилтын хүрээнд Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх авто замын 19 ТАХ тусгагдсанаас 15 ТАХ-ний ажлын гүйцэтгэл дунджаар 63 хувьтай, 4 ТАХ-г хэрэгжүүлэх санхүүжилт шийдвэрлэгдээгүй байна.
- 2.32. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, 2024, 2025 оны жилийн төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Аялал жуулчлалын гол зам дагуу амрах өртөө, түр отоглох цэг, зорин очих газруудад ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор”-ыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр байгуулахаар тусгагдсан.
- 2.33. Аялал жуулчлалын хөгжүүлэх хүрээнд 2024-2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 8 төсөл арга хэмжээг (3 ТАХ нийт 11 багцад хуваагдсан байна) 17,192.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч зарим ТАХ гүйцэтгэгч сонгон шалгараагүй байна. Үүнд:

Хүснэгт 12. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй ТАХ-ний хэрэгжилт

№	Төсөл, арга хэмжээний нэр	Багцын задаргаа	Төсөвт өртөг	Санхүүжсэн дүн	Тайлбар
Цогцолборын барилга					
1	Аялал жуулчлалын "Жавхлант" цогцолборын барилга /Завхан, Улиастай сум/		3,177.80	3,176.9	Улсын комисс хүлээж авсан
2	Аялал жуулчлалын "Хүслийн хад" цогцолбор /Хөвсгөл, Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон/		1,571.00	1,570.2	
3	Аялал жуулчлал, соёлын өв /Архангай, Цахир сум, Баянгол баг/		374.1		Гүйцэтгэгч шалгараагүй
4	Аялал жуулчлалын "Соёмбо" цогцолбор /Хөвсгөл, Мөрөн сум/	"Соёмбо цогцолбор" хүртэлх явган хүний зам, дугуйн зам	5,170.00	2,221.9	Барилгын ажлын явц 85%
		Дээрх замын холбоо сүлжээний нэмэлт угсралтын ажил		706.7	Улсын комисс хүлээж авсан
		"Соёмбо цэцэрлэгт хүрээлэн"-ийн ажил		1,166.4	
Амрах өртөө					
5	Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс/	Увс, Наранбулаг сум отоглох цэг	1,200.00	796.5	Барилгын ажлын явц 70%
		Увс, Цагаанхайрхан сум		399.8	Улсын комисс хүлээж авсан
Отоглох цэг					
6	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Увс, Малчин, Хяргас сум, Хяргас нуур/		1,500.00		Гүйцэтгэгч шалгараагүй
7	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Увс, Тариалан сум, Увс нуур/		1,874.10		
8	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Улсын хэмжээнд/	Булган, Баян-Агт сум		381.1	
		Өвөрхангай, Хужирт сум	2,325.00	381.1	

	Хэнтий, Өмнөдэлгэр сум	381.1	
	Завхан, Тэлмэн сум	361.9	
	Говь-Алтай, Хөхморьт сум	374.1	Улсын комисс хүлээж авсан
	Булган, Рашаант сум	409.2	

Эх сурвалж: 2024, 2025 оны Төсвийн тухай хууль, хэрэгжилт

- 2.34. Улсын комисс хүлээж авсан нийт 8 ажлын 3 нь багцад задарсан ТАХ, барилгын ажил явагдаж байгаа 2 (багцад задарсан) ТАХ-ны гүйцэтгэл 70-85 хувьтай, гүйцэтгэгч шалгараагүй нийт 6 төсөл арга хэмжээ байна.
- 2.35. Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн “Ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор барьж байгуулах тухай” 189 дугаар тогтоолын хавсралтаар 58 байршилд зам дагуу үйлчилгээний цогцолбор байгуулах зориулалтаар эзэмшүүлэх газрын байршлыг баталсан ч хэрэгжилт хангалтгүй, хэрэгжүүлэгч байгууллага үнэн зөв тайлагнахгүй байна. Тухайлбал:
- Тус тогтоолын 2 дахь хэсэгт “...хавсралтад заасан байршилд газрыг аймаг, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, холбогдох хууль тогтоомжийн дагуу эзэмшүүлэх ажлыг 2024 оны 2 дугаар улиралд багтаан зохион байгуулах...” гэснийг 21 аймгаас 13 аймаг нь хэрэгжүүлсэн гэж дүгнэсэн боловч тус 58 цэгээс гэрээ байгуулсан ч газрын асуудал шийдэгдээгүй 21 цэг, сонгон шалгаруулалт зарлаж, гэрээ байгуулаагүй 36 цэг, шаардлага хангаагүй хасах саналтай 1 цэг байна.
- 2.36. Увс аймаг дахь авто зам дагуух амрах өртөөнүүд нь тогтоолд тусгагдсан 58 байршилд хамаарахгүй бөгөөд Монгол Улсын Их хурлын 2023.05.30-ны өдрийн 39 дугаар тогтоол¹⁶, 2024.10.18-ны өдрийн 35 дугаар тогтоол¹⁷, Засгийн газрын 2024.05.01-ний өдрийн 189 дүгээр тогтоол¹⁸-ыг тус тус зөрчиж Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар байгуулсан байна.
- 2.37. Аялал жуулчлалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11-т "отоглох цэг" гэж аялал жуулчлалын эрэлт, байгаль орчны даацад нийцүүлэн хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхэд зориулагдсан, өөрийн стандарт бүхий, жуулчинд зориулсан түр байрлах үйлчилгээний цогц орчныг гэж заасан.
- 2.38. Улсын хэмжээнд отоглох цэгийн байршлыг тогтоох ажлыг аялал жуулчлалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт¹⁹ байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэх, 17.2 дахь хэсэгт²⁰ отоглох цэгийг хөрөнгө оруулалтаар барьж байгуулах хууль, эрх зүйн зохицуулалттай.
- 2.39. Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг байгуулах 5 байршилд гүйцэтгэгч шалгараагүй байна.
- 2.40. Иймд Аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд Улсын төсвийн хөрөнгөөр отоглох цэг байгуулах ажлыг эрчимжүүлэх, зам дагуух амрах өртөөг байгуулахтай холбоотой 189 дүгээр тогтоолын хавсралтад заасан байршилд газрыг эзэмшүүлснээр хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсаны дагуу төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Эрх шилжүүлэн авсан аялал жуулчлалын мэргэжлийн холбооны зарим гэрээний хэрэгжилт хангалтгүй байна.

¹⁶ Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай

¹⁷ Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай

¹⁸ Ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор барьж байгуулах тухай

¹⁹ Улсын аялал жуулчлалын бүс болон улсын тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын эрэлт, байгаль орчны даацыг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага отоглох цэг байгуулах байршлыг тогтооно.

²⁰ Энэ хуулийн 17.1-д заасан улсын тусгай хамгаалалттай газар нутагт байгуулах отоглох цэгийг улсын төсвийн, тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны, олон улсын төслийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар байгуулна.

2.41. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1²¹, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3²² дахь заалтыг тус тус үндэслэн Засгийн газрын 2023 оны “Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай” 370 дугаар тогтоол батлагдсан байна.

2.42. Уг тогтоолоор Аялал жуулчлалын мэргэжлийн холбоонд доорх чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхийг БОАЖ-ын сайдад зөвшөөрсөн байна.

Засгийн газрын 370 дугаар тогтоол

- Монгол Улсыг аялал жуулчлалын чиглэлээр гадаадад сурталчлах;
- Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх;
- Аялал жуулчлалын үйлчилгээнд олон улсын холбогдох стандартыг нэвтрүүлэх;
- Аялал жуулчлалын байгууллагын ангилал зэрэглэл тогтоох, хүний нөөцийн сургалт;
- Аялал жуулчлалын тухай хуулийн 10.5-д заасан жуулчны хөтөч-тайлбарлагчид үнэмлэх олгох, сунгах түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, мэргэжлийн ур чадварын зэрэглэл тогтоох.

2.43. Тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд БОАЖЯ, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоотой 2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр “Төрийн зарим чиг үүргийг нийтийн эрх зүйн хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх тухай” гэрээг 5 жилийн хугацаатай байгуулсан ба гэрээний 3.6²³ дахь заалтын дагуу 2024, 2025 онд дараах гэрээнүүдийг байгуулсан байна.

"Төрийн зарим чиг үүргийг нийтийн эрх зүйн хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх тухай" 2024.02.20, 24/39 дүгээр гэрээ	Гэрээ байгуулагдах үндэслэл: БОАЖ-ын Сайдын 2024 оны А/73 дугаар тушаал Гэрээ хүчингүй болсон үндэслэл: БОАЖ-ын Сайдын 2024 оны А/174 дүгээр тушаал батлагдсан
"Төрийн зарим чиг үүргийг нийтийн эрх зүйн хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх тухай" 2024.03.19, 24/74 дүгээр гэрээ	Гэрээ байгуулагдах үндэслэл: БОАЖ-ын Сайдын 2024 оны А/174 дүгээр тушаал
"Төрийн зарим чиг үүргийг Засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай" 2025.03.07, САЖЗЯ/25/22 дугаар гэрээ	Гэрээ байгуулагдах үндэслэл: Засгийн газрын 370 дугаар тогтоол

2.44. "Төрийн зарим чиг үүргийг нийтийн эрх зүйн хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх тухай" гэрээнүүдийн хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

- *Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын чиг үүрэг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд шилжсэн байхад 2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн БОАЖ-ын сайдтай байгуулсан Ерөнхий гэрээг шинэчилж байгуулаагүй байна.*
- *2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 24/74 гэрээний 9.4 дэх хэсэгт "Захиалагч талаас үл хамаарах шалтгаанаар (улсын төсөв, аялал жуулчлалын хөтөлбөрийн зардалд өөрчлөлт орох) ... бол талууд харилцан тохиролцож гэрээний хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулна" гэж заасан. Гэвч БОАЖ-ын Сайдын 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/449 дүгээр тогтоолоор АЖМХ-ны гүйцэтгэх арга хэмжээний төсвийг 1,500.0 сая төгрөгөөр ихэсгэж баталсан байхад тус гэрээний хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна.*

²¹ 1.Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно.

²² 6.4.3.иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой хөтөлбөр, арга хэмжээг тэдгээрээр гүйцэтгүүлэх чиглэл баримтлах;

²³ "Чиг үүргийн дагуу ирүүлсэн ажлын төлөвлөгөөг хянан үзсэний үндсэн дээр холбогдох хуульд үндэслэн зохих зардлыг жил бүр төсөвлөн батлуулж, хавсралтад тусган, хэрэгжүүлэх гэрээ байгуулан ажиллана"

- 2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн Ерөнхий гэрээний 5.2-т “Гэрээний биелэлтийг талуудын оролцоотойгоор сар, улирал бүр гаргаж, жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан дүгнэж, үнэлгээ өгч байна” гэж заасан боловч гэрээний хэрэгжилтийг ССАЖЗЯ-наас 2024 оны 04 дүгээр улирлын байдлаар дүгнэж, үнэлгээ өгч ажиллаагүй байна.

Монгол орныг түүх, соёл, газар нутгийн онцлогт тохируулан бүсчлэн хөгжүүлэх талаар бодлогын баримт бичиг, үзэл баримтлалд тусгагдсан ч аялал жуулчлалын бүсийг эцэслэн тогтоогоогүй байна.

2.45. Монгол Улсын нийгмийн орон зай эдийн засгийн хувьд Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатар гэсэн бүсэд хуваагдсанаас байгалийн үзэсгэлэнт газар, түүх, соёлын үнэт өв бүхий 21 аймаг, 334 сумаас бүрдсэн засаг захиргааны нэгжид хуваагдан байршиж байна.

2.46. Монгол Улсын Их Хурлаас “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг 2024 оны 64 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд Монгол Улсыг Хангайн, Баруун, Хойд, Төвийн, Зүүн, Говийн, Улаанбаатарын гэсэн бүсчлэлийн тогтолцоогоор хөгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Хангайн бүсэд: Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймаг;
- Баруун бүсэд: Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймаг;
- Хойд бүсэд: Булган, Орхон, Хөвсгөл аймаг;
- Төвийн бүсэд: Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймаг;
- Зүүн бүсэд: Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймаг;
- Говийн бүсэд: Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймаг;
- Улаанбаатарын бүсэд: нийслэл Улаанбаатар хот ба түүний дагуул хотууд.

2.47. Дээрх бүс нутгуудын онцлогт тохирсон худалдаа, үйлчилгээ, түүх соёл, рашаан сувилал, түүхэн дурсгалт газрууд, палеонтологийн нөөц зэрэгт түшиглэсэн аялал жуулчлалын тусгай бүсийг тодорхойлон хөгжүүлэхээр үзэл баримтлалд тусгагдсан.

2.48. ССАЖЯ-аас 2024 онд Аялал жуулчлалын бүсчлэлийг тодорхойлох үнэлгээний шалгуур үзүүлэлтийг боловсруулах, суурь судалгааны ажлыг гүйцэтгүүлэхээр “Аялал жуулчлалын бүсчлэлийн үндсэн чиг үүрэг, үзэл баримтлалыг бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулах” /20.0 сая төгрөгийн өртөгтэй/ 24/153 тоот гэрээг Хөгжлийн газарзүйн судалгааны хүрээлэнтэй байгуулсан байна.

2.49. Монгол орны аялал жуулчлалын бүс нутгийн хөгжлийг дэмжих, хэрэгжилтийг хангах аялал жуулчлалын төвлөрөл бүхий 57 орон зайн бүсийг тогтоосон байна. Улсын аялал жуулчлалын бүсийг тогтоох, хил зааг, менежментийн төлөвлөгөөний аргачлалыг боловсруулах ажлын хүрээнд 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр МУИС-ийн харьяа Хот, бүс нутгийн хөгжлийн судалгааны хүрээлэнтэй 50.0 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулсан байна.

2.50. Иймд улсын аялал жуулчлалын бүсийг нарийвчлан тогтоож, аялал жуулчлалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-т²⁴ заасны дагуу аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хорооны саналыг авч мөн хуулийн 16.3-т²⁵ зааснаар Засгийн газраар аялал жуулчлалын бүсийн хилийн заагийг эцэслэн тогтоож батлуулах шаардлагатай байна.

Аялал жуулчлалын тухай хуульд заасан журмыг батлах, салбарт мөрдөгдөж буй зарим үндэсний стандартыг шинэчлэх, шинээр батлах шаардлагатай байна.

2.51. Аялал жуулчлалын тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан тус хуулийн холбогдох хэсгүүдэд заасан 7 журам боловсруулан хэрэгжүүлэхээс Аялал жуулчлалын үйлчилгээний

²⁴ Улсын аялал жуулчлалын бүсийн хилийн заагийг тогтоохдоо газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хорооны саналыг авна.

²⁵ Улсын аялал жуулчлалын бүсийг тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарт байгаль, түүх, соёлын өв, аялал жуулчлалын нөөцийг хамгаалах зорилгод нийцүүлэн Засгийн газраас тогтоож, хилийн заагийг батална.

байгууллагын ангилал, зэрэглэл тогтоох журам, Даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хяналт тавих журмыг шинэчлэн батлаагүй байна.

- 2.52. БОАЖ-ын Сайдын 2009 оны “Аялал жуулчлалын байгууллагын ангилал тогтоох” журмыг мөрдөж байгаа нь агуулгын хувьд Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгатай нийцэхгүй, тур оператор, аяллын агентын буруутай үйл ажиллагааны улмаас үйлчлүүлэгчид учруулсан хохирлыг нөхөн төлөх, арилгах асуудлуудыг шийдвэрлэх хууль эрх зүйн орчин бүрдэж чадахгүй байна.
- 2.53. Иймд АЖТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.5²⁶, 14 дүгээр зүйлийн 14.5²⁷ дахь хэсэгт заасан журмыг боловсруулан баталж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна.
- 2.54. Монгол Улсад аялал жуулчлалын салбарт 22 стандарт хүчин төгөлдөр үйлчилж байгаагийн 60 орчим хувийг 2015 оноос өмнө баталсан байна. Жуулчны тав тух, аюулгүй байдал, үйлчилгээний байгууллагын өнөөгийн хэрэгцээ шаардлага, чанар, технологийн дэвшил, олон улсын өрсөлдөх чадвар, жуулчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхтэй уялдуулан стандартыг өөрчилж, шинэчилж, хөгжүүлэлт, хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон судалгаа хийх шаардлага үүссэн байна.
- 2.55. 2025 оны байдлаар Аялал жуулчлалын салбарт мөрдөгдөж буй дараах 4 үндэсний стандартыг шинэчлэх төслийг нээлттэй санал асуулга авахаар ССАЖЗЯ цахим сайтдаа байршуулсан байна. Үүнд:
- Амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд тавих ерөнхий шаардлага MNS 6043:2009;
 - Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ Зочид буудлын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага MNS 5927:2008;
 - Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ-Зочид буудалд тавих ерөнхий шаардлага MNS 4588:2008;
 - Дэн буудал. Ерөнхий шаардлага MNS 5738:2007;
- 2.56. Гэвч эдгээр төслүүд нь шинэчлэлийн бодит хэрэгцээ, шаардлагыг үндэслэлтэйгээр тооцоолоогүй, олон улсын стандартад нийцсэн эсэхийг судалгаагүйгээр зөвхөн хэлбэрийн засвар хийсэн байдлаар боловсруулсан нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 9.2²⁸, Аялал жуулчлалын тухай хуулийн 21.1.9²⁹ дэх заалтыг тус тус зөрчсөн байна.
- 2.57. Дээрх зочлох үйлчилгээний олон улсын стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд нийт 31.8 сая төгрөгийн санхүүжилттэй БНСУ-ын зочлох үйлчилгээний стандартыг судлан туршлага солилцох, сургалт зохион байгуулах, цаашлаад үндэсний хэмжээнд нэвтрүүлэх боломжийг олон улсын жишигтэй харьцуулан судлах ажлыг Төрийн захиргааны төв байгууллага хийж хэрэгжүүлэхээр ажлын даалгавар боловсруулсан байна.
- 2.58. Тухайн ажил бодит байдал дээр олон улсын стандарттай харьцуулсан судалгааг хийгээгүй, БНСУ-ын хоёр мэргэжилтнийг урьж, нийт 280 хүнд хоёр удаагийн сургалт зохион байгуулан сертификат олгосон, мөн “Hotel Study Tour 2024 in Korea” нэртэй сургалтын аяллыг зохион байгуулах ажлыг санхүүжүүлсэн байна.
- 2.59. Хийгдсэн ажлууд нь ажлын даалгаварт туссан зорилт, агуулгад нийцээгүй байхад уг ажлыг “бүрэн гүйцэтгэсэн” гэж дүгнэж, санхүүжилтийг бүрэн олгосон нь “Ажил гүйцэтгэх гэрээ”-ний 7.3-д Гүйцэтгэгчийн буруутай үйлдлээс шалтгаалан (ажлыг хугацаанд нь хүлээлгэн өгөөгүй,

²⁶ 6.5.Энэ хуулийн 6.2.3-т заасан аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын ангилал, зэрэглэлийг тогтоох, олгох, бууруулах, хүчингүй болгох болон уг үйл ажиллагааны үйлчилгээний хөлстэй холбоотой журмыг Засгийн газар батална.

²⁷ 14.5.Энэ хуулийн 14.1, 14.2-т заасан даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хяналт тавих журмыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран батална.

²⁸ Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуулийн 9.2 Үндэсний стандартын үзүүлэлт, шаардлага нь олон улс, бүс нутгийн стандартын шаардлагад нийцсэн байна.

²⁹ Аялал жуулчлалын тухай хуулийн 21.1.9. аялал жуулчлалын үйлчилгээний салбарт олон улсын стандартыг нэвтрүүлж байгаа аялал жуулчлалын байгууллагыг бодлогоор дэмжих;

гүйцэтгэсэн ажлын үр дүн ажлын даалгаварт нийцээгүй гэх мэт) тохиолдолд захиалагч нь төлбөр төлөх үүрэг хүлээхгүй гэсэн шаардлагыг хангаагүй, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байгааг харуулж байна.

- 2.60. Салбарын яамнаас шинэчлэх шаардлагатай стандартын судалгаа хийж, шинэчлэх талаар арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй нь салбарын стандартчиллын шинэчлэл удаашрах, олон улсын шаардлагад нийцэхгүй байх шалтгаан болж байна.
- 2.61. Түүнчлэн аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлж буй стандартуудад улсын үзлэг хийгдэж байгаагүйгээс өнөөгийн хэрэгцээ, шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох шалгуур үзүүлэлт бүрдээгүй, шинээр боловсруулах, шинэчлэн сайжруулах ажил тодорхойгүй байна.
- 2.62. Цаашид аялал жуулчлалын салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанарын үндэсний болон орчуулсан олон улс, бүс нутгийн стандартуудыг хүчингүй болгосон, нэмэлт, өөрчлөлт оруулсан, дахин хянасан эсэхийг тогтмол хянаж, стандартчиллын ажлын төлөвлөгөөнд тусгаж ажиллах нь зүйтэй байна.

Аялал жуулчлалын мэдээллийн нэгдсэн сангүйгээс олон нийтийг бодитой мэдээллээр хангаж чадахгүй байна.

- 2.63. Монгол Улсыг гадаадад сурталчлах нэгдсэн вэбсайт, аппликэйшн хөгжүүлэх, дижитал контент бэлтгэх 200.0 сая төгрөгийн өртөг бүхий www.mongoliatravel.guide системийн гэрээг БОАЖЯ 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдөр “Монголын аялал жуулчлалын холбоо” ТББ-тай байгуулж, гэрээний ажлын даалгаварт дараах шаардлагыг тусгасан байна. Үүнд:

- Цахим вэбсайт хөгжүүлэлт хөгжүүлэлт; /Version 1,2, Alpha version/
- Аппликэйшн хөгжүүлэлт; / Version 1,2, Alpha version /
- Вэбсайт болон Аппликэйшнийг App store дээр байршуулах;
- Вэбсайт болон Аппликэйшний брэндинг хийх;
- Контент үйлдвэрлэлт; /НҮБ-ын албан ёсны 6 хэл дээрх араб, хятад, англи, франц, орос, испани болон солонгос/
- Дижитал сэтгүүл; /10-12 контент, 2 сард нэг удаа/ Видео мэдээ мэдээлэл / 7 хоногт 1 удаа/, Мэдээ, мэдээлэл /өдөрт 2-3 /
- Цаг үеийн шинж чанартай мэдээлэл Монгол, НҮБ-ын албан ёсны 6 хэл дээрх араб, хятад, англи, франц, орос, испани болон солонгос хэл дээр бэлтгэх

- 2.64. Дээрх ажлын даалгаврын дагуу системийг хөгжүүлсэн, гэрээг бодитой дүгнэж хүлээж авсан баримт байхгүй, 2025 оны байдлаар үйл ажиллагаа хаагдсан байна.
- 2.65. Тус ажлын хүрээнд “Монголын аялал жуулчлалын холбоо” ТББ нь 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдөр ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу сонгон шалгаруулалт явуулахгүйгээр “Ворлд Плас дижитал” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээг шууд байгуулсан байна.
- 2.66. Түүнчлэн БОАЖЯ нь “Монголын аялал жуулчлалын холбоо” ТББ болон, гүйцэтгэгч байгууллагыг ажлын даалгаварт туссан ажлыг гүйцэтгээгүй байхад систем хөгжүүлэлтийн төлбөрийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт³⁰, Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэг³¹, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3 дахь заалт³², ТБОНӨХБАҮХАТХ-ийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт³³ заасантай тус тус нийцэхгүй, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

³⁰ 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

³¹ Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.

³² 4.2.3.хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх;

³³ 32.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэнэ.

- 2.67. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2024 оны 240/11-20 дугаар албан бичгээр Mongoliatravel.guide цахим хуудсыг гүйцэтгэсэн “Ворлд Плас Дижитал” ХХК-ийн хуулийн этгээдийн бүртгэлд 2025 оны байдлаар үйл ажиллагаанд хориг тавьсан төлөвтэй байна.
- 2.68. Аялал жуулчлалын салбарын албан ёсны цахим хуудасны ашиглалтын эрхийг “Аялал жуулчлалын хөгжлийн төв” ТӨААТҮГ-т шилжүүлж, тус байгууллага нь ТББ-тай цахим хуудасны серверийн хөгжүүлэлтийг сайжруулах, хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 19.8 сая төгрөгийн өртөгтэй гэрээ байгуулан, хэвийн ажиллагааг хангаж ажилласан байна.
- 2.69. “Монголын цахим аялал жуулчлалын холбоо” ТББ нь гэрээний дагуу www.mongoliatravel.guide вэбсайтын хөгжүүлэлт, ашиглалтын тайланг боловсруулж, эх кодыг ССАЖЗЯ-д 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр хүлээлгэн өгсөн байна.
- 2.70. ССАЖЗ-ын Сайдын баримт бичгээр баталгаажуулаагүй үүрэг чиглэлийн дагуу www.mongoliatravel.guide вэбсайтын систем, программ хангамжуудын судалгаа, ашиглалтын байдалд хяналт-шинжилгээ хийлгүй эх код, домэйн хаягийг хаасан нь Төсвийн тухай хуулийн 6.4.12-т заасан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 36.1.1-д заасан удирдлагын шийдвэр, ажил хэргийн явцыг тухай бүрд нь баримтжуулах; 36.1.4.баримт бичгийг мэдээллийн эх сурвалж, хуулийн хүчинтэй байх шаардлагад нийцүүлэн зохиож хөтлөх заалтыг тус тус зөрчсөн байна.
- 2.71. “Ухаалаг засаг II” дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжих “Цахим аялал жуулчлал” төслийн хүрээнд аялал жуулчлалын нэгдсэн системийг дахин шинээр боловсруулах зорилгоор БОАЖЯ /хуучин нэршлээр/ нь “Күүп аутсорсинг” ХХК-тай Монгол Улсын аялал жуулчлалын портал хөгжүүлэх ажлын даалгавар боловсруулах” зөвлөх үйлчилгээний 10.0 сая төгрөгийн өртөгтэй, “24/297 дугаар гэрээг 2024 оны 6 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан байна.
- 2.72. Уг гэрээгээр ажлын даалгавар боловсруулах гэрээний биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр хүлээн авах байсан ч 2025 оны 11 дүгээр сарын байдлаар гэрээний үүрэг хэрэгжээгүй байна.

Дүрслэл 5. Аялал жуулчлалын салбарын цахим платформын зураглал



- 2.73. Иймд дээрх www.mongoliatravel.guide систем хөгжүүлэлтийг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, ТБОНӨХБАУХАТХ-ийг холбогдох заалтыг тус тус зөрчсөн байх тул зарцуулсан санхүүжилтийг буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт, хууль зөрчсөн байж болзошгүй үйлдлийг хууль хяналтын байгууллагад шалгуулахаар шийдвэрлэлээ.

Жуулчдын тоон мэдээллийн талаарх статистик үзүүлэлтийг аргачлалын дагуу боловсруулаагүй, аялал жуулчлалын салбараас эдийн засагт оруулж буй хувь нэмрийг бодитой тооцох боломжгүй байна.

2.74. Аялал жуулчлалын тухай хуулийн 4.1.1³⁴-д заасны дагуу Монгол улсын хилээр нэвтэрсэн гадаадын иргэдийн тоогоор Үндэсний статистикийн хороо жил бүр Монгол улсад аялж буй жуулчдын тоог тодорхойлж байна.

2.75. Монгол Улсад аялал жуулчлалын статистикийн үзүүлэлтийг олон улсын жишигт нийцүүлэн Үндэсний статистикийн хорооны даргын 2023 оны А/177 дугаар тушаалаар нийт 43 үзүүлэлтэд үндэслэн статистик мэдээг тооцож гаргахаар “Аялал жуулчлалын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал, маягт, нөхөх заавар” шинэчлэн баталсан байна. Тухайлбал:

- Гадаад, дотоод жуулчдын тоо, зардал;
- Жуулчлалын чиглэлээр хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн орлого;
- Тусгай хамгаалалттай газар нутагт нэвтэрсэн тээврийн хэрэгслийн тоо;
- Жуулчны эвент арга хэмжээ, зарцуулсан төсөв, олсон орлого, оролцсон гадаад жуулчдын тоо;
- Гадаад жуулчдын нийт зардлын үйлчилгээний экспортод эзлэх хувь;
- Гадаад, дотоод жуулчдын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь....гэх мэт

2.76. ССАЖЗЯ нь статистикийн үзүүлэлтийг тооцохдоо (2011 оны 01/180 дугаар тушаалаар батлагдсан) хүчингүй болсон хуучин аргачлалыг ашиглаж байгаа нь аялал жуулчлалын салбарын статистик мэдээ, өсөлт, бууралт, дотоодын эдийн засагт оруулах хувь нэмрийг үнэн зөв бодитой тооцох боломжгүй, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийг үндэслэлтэйгээр төлөвлөх, олон улсын өрсөлдөх чадварыг урагшлуулахад сөргөөр нөлөөлөх, хөгжлийн бодлого, стратеги оновчгүй боловсруулагдах эрсдэлтэй байна.

2.77. БОАЖ-ын Сайдын “Маягт түүнийг нөхөх зааврыг батлах тухай” 2024 оны А/167 дугаар тушаалаар “Аялал жуулчлалын тухай үйл ажиллагаа эрхэлдэг АНН, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний улирлын мэдээ, Тусгай хамгаалалттай газар нутагт хяналтын цэгээр нэвтэрсэн иргэн тээврийн хэрэгслийн улирлын мэдээ, жуулчны эвент арга хэмжээ”-ний бүртгэлийн мэдээний маягт, зааврыг тус баталсан байна.

2.78. Уг маягт, зааврыг цахимжуулах, хялбаршуулахаар БОАЖЯ-наас 2024 оны 24/335 тоот “Ажил гүйцэтгэх гэрээ”-г ажлын даалгаваргүйгээр АЖМХ-той байгуулсан байна.

2.79. Гэвч АЖМХ нь туслан гүйцэтгэгч “Монгол Компьютинг ХХК”-аар уг ажлыг гүйцэтгүүлэхдээ захиалагчийн ажлыг “Аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгчдийн бүртгэл мэдээллийн болон аялал жуулчлалын салбарын тоон мэдээллийн статистик хуудас, захиалагчийн вебсайт хөгжүүлэх” гэж өөрчлөн, 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр 50.0 сая төгрөгийн өртөгтэй ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр гэрээг дүгнэсэн байна.

2.80. ССАЖЗЯ-аас 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдөр АЖМХ-той байгуулсан гэрээг дүгнэхдээ “Монголын цахим аялал жуулчлалын холбоо” ТББ-ын хийж гүйцэтгэсэн mongoliatravel.guide цахим системийн хөгжүүлэлт, ашиглалтын өөр ажлын тайланг үндэслэж, санхүүжилтийг бүрэн олгосон байна.

2.81. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төрийн өмчит мэдээллийн системийг³⁵ Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны мэдээллийн вэбсайт болгон ашиглаж, биет бус үндсэн

³⁴ . “Аялал жуулчлал” гэж хүн өөрийн байнга оршин суудаг газар нутгаасаа өөр газарт 90 хоног хүртэлх хугацаагаар суралцах, ажил хөдөлмөр эрхлэхээс бусад зорилгоор аялан явахыг;

³⁵ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 үйлдвэрлэл, ажил үйлчилгээний үр дүнд бий болсон эд хөрөнгө;

хөрөнгөд үндэслэлгүйгээр шилжүүлсэн нь ТБОНӨТХ-ийн 27 дугаар зүйлийн 1³⁶, Аялал жуулчлалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1³⁷ дэх хэсэгт заасантай тус тус нийцэхгүй байна.

Монгол Улсын албан ёсны статистик үзүүлэлт аялал жуулчлалын орлогыг бодитой тооцоолохгүй байна.

2.82. Статистик үзүүлэлтүүдийг статистикийн тухай хуулиар зохицуулж, хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “үйлдвэрлэл, шинжлэх ухаан, технологийн статистик үзүүлэлт”-ийн хүрээнд аялал жуулчлалын орлого, жуулчдын тоо мэдээлэл нь аялал жуулчлалын салбарын статистикт хамаарч байна.

2.83. Монгол банк аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран “Жуулчдын зардлын түүвэр судалгаа”-г Монгол Улсын албан ёсны статистик үзүүлэлт аялал жуулчлалаас олж буй орлогыг тодорхойлох, төлбөрийн тэнцлийн статистикт ашиглах, статистик мэдээллийн үнэн бодит байдлыг хангах, чанарыг сайжруулахын тулд эрэлт, нийлүүлэлт талаас тодорхойлох түүвэр судалгааг 2012 оноос эхлэн 2-3 жилийн давтамжтай гүйцэтгэж ирсэн, бөгөөд хамгийн сүүлд 2019 онд хийж гүйцэтгэсэн байна. Тухайлбал:

■ *Эрэлт талаас /жуулчид/: Судалгаанд нийт 1543 гадаад жуулчид хамрагдсанаас 1436 хүний санал асуулгыг хүчинтэйд тооцож шинжилгээнд ашигласан. Тус судалгаанд нийт 55 орны жуулчид хамрагдсан бөгөөд БНСУ, АНУ, Франц, Герман, Япон, БНХАУ, ОХУ, Их Британи улсуудын жуулчид түлхүү хамрагдсан байна. Түүвэр судалгаагаар аялагчдын насны ангилал, аяллын зорилго, мэдээллийн эх сурвалж, зардлын задаргаа, худалдан авсан бүтээгдэхүүн, хүндрэл бэрхшээл, сэтгэл ханамж бусад асуудлыг тодорхойлсон байна.*

■ *Нийлүүлэлт талаас /тур оператор/: Судалгаанд нийт 41 тур оператор оролцсоноос 34 байгууллагын санал асуулгыг хүчин төгөлдөр хэмээн үзэж үйл ажиллагаа, мэдлэг ур чадвар, идэвхтэй үе, дэмжлэг цаашид авах арга хэмжээ, орлого зардал санхүүжилтийн талаар судалгааг авсан байна.*

2.84. Аялал жуулчлалын салбарт гадаад жуулчдаас оруулж буй дундаж зарцуулалтыг дээрх судалгааны суурь түвшнээр тооцон ирсэн, харин 2025 оны байдлаар шинэчилсэн суурь үзүүлэлт байхгүй, аялал жуулчлалын салбараас олсон орлогыг бодитой тооцож чадахгүй байна.

2.85. Монгол Улсын ДНБ 2024 онд 32.1 их наяд төгрөг байгаагаас 5.6 их наяд төгрөгийг Аялал жуулчлалын салбар эзэлж байна. Өмнөх оноос 1.5 (4.9%) их наяд төгрөгөөр өсөхөд уул уурхай, олборлолтын салбарын нэмэгдэл өртөг 419.2 (10.8%) тэрбум төгрөгөөр, үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 1.5 (9.8%) их наяд төгрөгөөр нэмэгдсэн байна.³⁸

2.86. Монгол Улсын аялал жуулчлалд гарч буй ахиц дэвшил, хүрэлцэн ирж буй жуулчдын тоо, бусад салбарт үзүүлж буй эерэг өөрчлөлт, эдийн засагт оруулж буй хувь нэмрийг тооцон гаргаснаар тус салбарын хөгжил үйл явцыг үнэн зөв тодорхойлогдож, статистик мэдээлэл бодитой гарах нөхцөл бүрдэхээр байна.

³⁶ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг 27 дугаар зүйлийн 1 Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно

³⁷ Аялал жуулчлалын тухай хуулийн 27.1 Аялал жуулчлалын салбарын судалгаа, шинжилгээ, статистик мэдээллийн нэгдсэн сан /цаашид "Аялал жуулчлалын мэдээллийн сан" гэх/-г аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага цахим хэлбэрээр бүрдүүлнэ

³⁸ Үндэсний статистикийн хороо “Дотоодын нийт бүтээгдэхүүн, 2024 онд”

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. “Аялал жуулчлалын үндэсний хөтөлбөр”, “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-ийг Засгийн газрын 2021 оны 55 дугаар хуралдааны тэмдэглэлээр “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” жагсаалтад тусгасан ч хүчингүй болгосон тогтоол гараагүй, эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд (Legalinfo.mn) хүчин төгөлдөр байна.
2. Захиргааны ерөнхий хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллага гадаад улсын ижил төрлийн захиргааны байгууллага, хуулийн этгээдтэй байгуулах байгууллага хоорондын гэрээ байгуулах журам”-д “Хуулийн этгээд” гэсэн субъектийг орхигдуулсан нь хуулийн заалтын агуулга алдагдан, хяналтын хүрээ хязгаарлагдаж, гадаадын хуулийн этгээдтэй хийгдэж байгаа гэрээнүүд холбогдох хууль, журмаас гадуур, бүртгэлгүйгээр хийгдэж байна.
3. “Монгол улсын аялал жуулчлалын үндэсний нэгдсэн стратеги”-ийг боловсруулах гэрээний үе шатанд хийгдэх анхан шатны баримт бичгүүд, үйл ажиллагаа, мэдээлэл лавлагааны баримт бичгийг тухай бүр баримтжуулан гэрээг дүгнэхгүйгээр стратегийг баталсан байна.
4. Аялал жуулчлалын бодлого хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь үндсэн хэрэгжүүлэгчийнхээ хүрээнд бусад хамтран хэрэгжүүлэгч төрийн байгууллагуудтай хамтын ажиллагаа хангалтгүй, мэдээлэл солилцоо дутмаг, хэрэгжилтийг нэгтгэн дүгнэх, тайлагнах чиг үүргийг хэрэгжүүлэхгүй байгаа нь салбарын бодлогын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.
5. Засгийн газрын 2024 оны “Ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор барьж байгуулах тухай” 189 дүгээр тогтоолын хавсралтаар 58 байршилд “газрыг эзэмшүүлэх ажлыг 2024 оны 2 дугаар улиралд багтаан зохион байгуулах...” -ыг аялал жуулчлал хариуцсан сайд, газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар дарга, аймаг, сумын засаг дарга нарт тус тус үүрэг болгосон ч 58 цэгийн газрын асуудал шийдэгдээгүй, тогтоолын хэрэгжилт үр дүнгүй байна.
6. Аялал жуулчлалын салбарт 2024-2025 онд хэрэгжүүлж буй 55 төсөл, арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг нийт 5,740.0 сая төгрөг байхаар ажил тус бүрээр бүхэл дүнгээр төлөвлөсөн нь шаардлагатай хөрөнгийн тооцоо судалгаа хийгдээгүйтэй холбоотой байна.
7. Арилжааны банкны эх үүсвэртэй Аялал жуулчлалын салбарыг дэмжих зээлд Засгийн газрын хүүгийн татаас олгохдоо санхүүжилтийн ерөнхий гэрээний шаардлага хангаагүй иргэн, аж ахуй нэгжид зээлийн хүүгийн хөнгөлөлт үзүүлсэн байна.
8. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам нь Аялал жуулчлалын мэргэжлийн холбоотой байгуулсан гэрээг шинэчлээгүй, гүйцэтгүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийг бодитой дүгнээгүй, 2,774.6 сая төгрөгийн үнийн дүнтэй 18 ажил гүйцэтгэх гэрээг нөхөж байгуулсан байна.
9. Төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж буй Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нь худалдан авах үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллахгүй байна.

10. Аялал жуулчлалын салбарын шинэчлэгдэж буй стандартуудын бодит хэрэгцээ, шаардлагыг үндэслэлтэйгээр тооцоолоогүй, олон улсын стандартад нийцсэн эсэхийг судлаагүй, шинээр боловсруулах, шинэчлэн сайжруулах стандарт тодорхойгүй байна.
11. Монгол Улсыг гадаадад сурталчлах нэгдсэн вэбсайт, аппликэйшн хөгжүүлэх, дижитал контент бэлтгэх 200.0 сая төгрөгийн өртөг бүхий Mongoliatravel.guide систем хөгжүүлэх ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн хуулийн тус тус зөрчиж шууд гэрээ байгуулсан, программ хангамжийн судалгаа, ашиглалтын байдалд хяналт-шинжилгээ хийгээгүйгээр ашиглалтыг зогсоосон.
12. Монгол Улсын аялал жуулчлалын статистик үзүүлэлтийг Үндэсний статистикийн хорооны даргын “Аялал жуулчлалын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал, маягт, нөхөх зааврыг шинэчлэн батлах тухай” 2023 оны А/177 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу боловсруулаагүй, эдийн засгийн үзүүлэлтийг бодитой тооцож чадахгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Монгол Улсын Ерөнхий сайд, Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хорооны даргад:

1. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Байгууллага хоорондын гэрээ байгуулах журам”-ын зорилтын агуулгыг Захиргааны ерөнхий хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-т заасанд нийцүүлэх;
2. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор барьж байгуулах тухай” 189 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан 58 байршилд газар эзэмшүүлэхтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд:

3. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 55 дугаар хуралдааны тэмдэглэлээр “Тогтоол хүчингүй болсон тооцох тухай” жагсаалтад тусгасан “Аялал жуулчлалын үндэсний хөтөлбөр”, “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-ыг хүчин төгөлдөр байх эсэхийг тодорхой болгох;
4. Аялал жуулчлалын хөтөлбөрийн зардлыг тооцоо, судалгаанд үндэслэн төлөвлөх, хэрэгжүүлж буй арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн үр дүнг тооцож, гэрээг бодитой дүгнэх;
5. Аялал жуулчлалын салбар хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хуулийн хүрээнд бусад төрийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа сайжруулах, аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр гарсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг үндсэн хэрэгжүүлэгчийнхээ хүрээнд нэгтгэн дүгнэх, тайлагнах;
6. Гадаадын хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний үлдэгдэл төлбөрийг хэмнэлттэй, үр ашигтай төлөвлөх, зарцуулах зарчмын баримталж санхүүжүүлэхгүй байх, хяналт тавьж ажиллах;
7. “Аялал жуулчлалын салбарыг дэмжих зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээ болон “Төрийн зарим чиг үүргийг нийтийн эрх зүйн хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх тухай” гэрээг дүгнэж, шинэчлэн байгуулах, арилжааны банкнуудтай тооцоо нийлж, баталгаажуулах;
8. Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдахтай холбоотой үйл ажиллагааг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллуулах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
9. Монгол Улсын аялал жуулчлалын статистик мэдээг Үндэсний статистикийн хорооны даргын 2023 оны А/177 дугаар тушаалаар баталсан “Аялал жуулчлалын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал, маягт, нөхөх зааврыг шинэчлэн батлах тухай” аргачлалын дагуу боловсруулж, олон нийтэд мэдээлэх;
10. Аялал жуулчлалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт заасан “Энэ хуулийн 6.2.3-т заасан аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын ангилал, зэрэглэлийг тогтоох, олгох, бууруулах, хүчингүй болгох болон уг үйл ажиллагааны үйлчилгээний хөлстэй холбоотой журмыг Засгийн газар батална” гэсний дагуу журмыг боловсруулан, батлуулах;
11. Аялал жуулчлалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэгт заасан “Энэ хуулийн 14.1, 14.2-т заасан даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хяналт тавих журмыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран батална” гэсний дагуу журмыг батлах, мөрдөх.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Үндэсний аудитын газраас 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 3451 тоот албан бичгээр Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд /Ч.Ундрэм/-д аудитын тайлангийн төсөлд санал авахаар хүргүүлсэн боловч Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан хугацаанд санал ирүүлээгүй тул 18.4-т заасны дагуу саналгүйд тооцсон болно.